МБҮА
SINCE 2009
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Зөв зүгт
манлайлна

1 ЖИЛИЙН ТАЙЛАН



МБҮА ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ

МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСӨЛД ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАГЧДАА ОРОЛЦУУЛЖ ЧАДСАН

АГУУЛГА

2024.10.25 — 2025-10.25

01 МБҮА ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ 03

02 МБҮА ТББ-15 ЖИЛИЙН ОЙ 04-05

03 ФОРУМ, АРГА ХЭМЖЭЭ 06-11

04 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТУХАЙ 12-17

05 МЕГА ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД 18-28

06 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨГЖҮҮЛЭЛТ, СУРГАЛТ 29-26

07 ОРОН НУТАГТ САЛБАР ЗӨВЛӨЛТЭЙ БОЛЛОО 37-38

08 “ДУЛААН ШИЙДЭЛ2” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД 39-43

09 ТУЛГАМДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ 44-54

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ НЬ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААРАА ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛААР М.БАТСҮХИЙГ ТОМИЛЛОО



МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн ээлжит III хурал нь 2024.10.25-ны өдөр болж МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирлаар Г.Батсүхийг томиллоо.

МБҮА ТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧДИЙН НЭРЭМЖИТ ДУРСАМЖ-15 УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МБҮА ТББ нь 2009 онд Жигүүр гранд групп ХХК-ийн захирал Д.Баттөр, Цаст констракшн ХХК-ийн захирал Н.Баярсайхан, Заг ХХК-ийн захирал Б.Нэмэхбаатар, Монгол Базальт ХХК-ийн захирал Л.Ариунболд, Нийслэл Өргөө ХХК-ийн захирал Б.Ганзориг нарын таван захирлын бүрэлдэхүүнтэй үүсэн байгуулагдаж байсан бөгөөд 2024 онд 15 жилийн ойг тэмдэглэхтэй холбогдуулан МБҮА ТББ-ын үе үеийн Ерөнхийлөгчдийн нэрэмжит “ДУРСАМЖ ҮДЭШ – 15 ЖИЛ” арга хэмжээг Гишүүдийнхээ хүрээнд зохион байгуулж байгууллагын анхны үүсэн байгуулагдаж байсан түүх, дурсамжуудаа хүүрнэж, жаргал зовлонгоо хуваалцсан халуун дулаан үдшийг өнгөрүүллээ. Ерөнхийлөгчдийн нэрэмжит “ДУРСАМЖ ҮДЭШ – 15 ЖИЛ” арга хэмжээний үеэр байгууллагынхаа ойн арга хэмжээнд зориулан Цаст констракшн ХХК-Платинум, NBIK ХХК, Эрчим инженеринг ХХК, Буянпил ХХК Алтан багц, Грийн ресурс ХХК, Оргил Жим ХХК, Бодь интернэшнл ХХК нар дэмжигч байгууллагаар оролцож хандив өргөлөө.



МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ-ЫН 15 ЖИЛИЙН ОЙГ АЖЛЫН АЛБА ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ нь барилгын төсөл хөгжүүлэгчид, гүйцэтгэгчид, гэрээлэгчид, архитектур, зураг төсөл зохиогчид, барилгын ханган нийлүүлэгчид, зөвлөх үйлчилгээний компаниуд, материал үйлдвэрлэгчид, үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын зэрэг 200 орчим гишүүн компаниудаас бүрдсэн том гэр бүл болоод байгаа ба өнөөдөр манай гишүүн компаниудын цаашаа ажил олгож, хамтран ажиллаж буй компаниудыг оруулаад тоон дүнгээр авч үзвэл 100,000 илүү мянган ажлын байрыг бид улсдаа бий болгож явна.

2008 оны дэлхийн санхүүгийн хямрал Монголын эдийн засагт нөлөөлж түүний дотор барилга үл хөдлөх хөрөнгийн салбарт огцом уналт бий болсон цаг үед энэ чиглэлээр ажилладаг бидний хэдэн нөхөд нийлж хямралыг хэрхэн бага хохиролтой даван туулах, түүний төлөө нэгдэж хамтарч ажиллах зорилгоор МБҮА-ыг анх байгуулж байлаа.

МБҮА ТББ-ын зорилт нь улс үндэснийхээ хөгжлийн зорилттой нэгдмэл, органик холбоотой байж улсынхаа хөгжилд хувь нэмэр оруулах, ойрын зорилт нь олон айл, байгууллагуудыг орон байр, ажиллах орчинтой, амар түвшин ажиллаж, амьдрах боломжийг бүрдүүлэх явдал юм. Нэг үгээр хэлбэл бидний зорилт бол Монгол Улсын хөгжил дэвшил гэж үздэг.

Бид өнгөрсөн 15 жилийн хугацаанд хөгжлийн стратеги төлөвлөгөө гарган ажиллаж өөрийн гишүүд, салбарын ТББ-ууд болон Төрийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд багагүй үр дүнд хүрчээ. Энэ хугацаанд Монгол Улсын эдийн засагт тохиолдсон удаа дараагийн хямрал, хүндрэлүүдийг даван туулахад салбарын дуу хоолой болон манлайлан ажиллаж ирсний үр дүнд Төр засгаар тодорхой шийдвэрүүд гаргуулж, үр дүнд нь зөвхөн гишүүдэд төдийгүй энэ салбарт ажиллаж буй нийт бизнес эрхлэгчдэд эерэг нөлөөллүүд бий болгож иржээ.

Барилгын бизнесийн орчныг сайжруулах, зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулах ажлыг манлайлан ажилласны үр дүнд энэ ажлыг ТББ- уудаар гүйцэтгүүлэх шийдвэрийг төр засгаар гаргуулан, 7 дахь жилдээ салбарын 6 холбоодтой хамтран амжилттай гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар уг үйл ажиллагаа бүрэн цахимжиж, байгууллагууд ажлын 5-7 хоногт зөвшөөрлөө авдаг болсон байна.

Мөн бид гадаад харилцаагаа тогтмол өргөжүүлэн ажилласны үр дүнд Ази болон Баруун Номхон Далайн Орнуудын Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүнээр 5 дахь жилдээ ажиллаж, олон талт хамтын ажиллагааны үр дүнд эдгээр байгууллагуудын дэмжлэгтэйгээр Олон

Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо, FIDIC н Түншлэгч гишүүнээр сонгогдон идэвхтэй ажиллаж байна. Үүний үр дүнд бид саяхан Барилга Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын эрхийг авч үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болж бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Мөн бид Франц Улсын Жэрэс Монгол ОУТББ хамтран Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын айлуудын дулаан алдагдлыг бууруулахад мэргэшсэн технологийн сургалтаар дамжуулан бригадуудаар дулаалга хийлгүүлэх сургалт, дадлагад чадавхжуулах, нийслэлийн төлөвлөлтгүй бүсэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцыг барихад зөвлөгөөг өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээг үзүүлэх зорилготой төслийг хэрэгжүүлэхээс гадна 15 жилийн түүхтэй МБҮА -ыг өндөр хөгжилтэй орнуудын ижил төрлийн холбоодтой харьцуулахад туршлага дутмаг, хүнээр бол өсвөр насандаа яваа хэдий ч энэ нас бол хамгийн эрч хүчтэй нас юм.

Монголын барилгын салбарын хөгжилд зөв манлайлал үзүүлж ажиллана гэсэн уриатай ТББ -ын хувьд бид цаашдын үйл ажиллагаандаа дараах хэдэн чиглэлийн хамтын ажиллагааг онцгойлж байна.

Нэгдүгээрт: Дотооддоо улам олуулаа болон нэгдэн нягтарч, супер гүйцэтгэх чадвартай холбоо болох

Хоёрдугаарт: Хэрэглэгчидтэй нягт хамтран ажиллан, тэдэнд чухам ямар бүтээгдэхүүн хэрэгтэй байгаа, барилгаас шалтгаалсан ямар асуудлууд,хүндрэл бэрхшээлүүд бий болоод байгааг сайн мэддэг байх

Гуравдугаарт: Төр, засгийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллах замаар улс орны хөгжлийн зорилт, стратегитэй ажлаа уялдуулан ажиллах

Дөрөвдүгээрт: Харилцан уялдаатай салбарын болон бусад салбарын ижил төрлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллах Ингэснээр салбарт тулгамдаж буй асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлээд явах боломж бүрдэнэ.

Тавдугаарт: Хөгжингүй орнуудын ижил төрлийн холбоодтой маш сайн хамтарч ажиллах замаар барилгын салбарын орчин цагийн хөгжлийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах талаар ажиллахаар төлөвлөж байна.

Ойн арга хэмжээгээр тус байгууллагад өнөөдрийг хүртэл санхүү болоод цаг зав, сэтгэл зүрхээ гарган мөр зэрэгцэн яваа ЭКО КОНСТРАКШН ХХК, ЭС ДИ ИНЖЕНЕРИНГ ЭНД КОНСТРАКШН ХХК, НБИК ХХК, ЭРЧИМ ИНЖЕНЕРИНГ ХХК, БОДЬ ИНТЕРНЭШНЛ ХХК, ЗАГ ГРУПП ХХК нартаа Ерөнхийлөгчдийн нэрэмжит шагналыг гардууллаа.

"CONSTRUCTION MARKET–2025" ФОРУМ-ААР БАРИЛГЫН САЛБАРТ ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДЛУУДЫГ ХЭЛЭЛЦЛЭЭ



Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал барилга, бүтээн байгуулалтын салбарт хэрхэн нөлөөлж буй болоод, барилгын зах зээлийн нөхцөл байдал, санхүүжилт, хөрөнгө оруулалт болон судалгааны нэгдсэн мэдээ, мэдээллийг хүргэх "CONSTRUCTION MARKET–2025" форумыг Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь Хот байгуулалт, орон сууцжуулалтын яамтай хамтран 2025.04.30-ны өдөр Туушин зочид буудлын Соёмбо танхимд зохион байгууллаа.

Уг арга хэмжээг МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү нар нээх бөгөөд төр болоод хувийн хэвшлийн төлөөллүүд Монгол Улсын томоохон барилга бүтээн байгуулалтын хөрөнгө оруулагчид, барилга угсралтынхан, зураг төсөл, архитектур, материал үйлдвэрлэгч нар гээд 250 орчим оролцогчид оролцлоо.

Форумын хүрээнд холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг дэлхийн эдийн засгийн хамгийн сүүлийн мэдээллийг сонсож уг арга хэмжээнээс гарах зөвлөмжийг ирээдүйн үйл ажиллагаандаа тусгах, улс орнуудыг төсөв хөрөнгө, хөрөнгө оруулалтын орчин, мега төслүүдээ эрэмбэлж ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс аль болох хохирол багатай, ухаалаг, зөв төлөвлөлтийг хийхийг зөвлөсөн арга хэмжээ болж өнгөрлөө.

ЗӨВЛӨМЖ:

ТӨРӨӨС БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

-Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх II үе шат хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах,

-Бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах,

-Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад салбарын төрийн болон ТББ-д, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг сайжруулах,

ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ

-Мэргэжлийн стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, шинэчлэх процедурыг боловсронгуй болгох,

-Мэргэжлийн сургалт явуулах эрх олгох журмыг боловсронгуй болгох,

-Салбарын гэрээг боловсронгуй болгож Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ны гэрээг нэвтрүүлэх,

-Гадаад ажиллах хүчний эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, удирдлага, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох,

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ БА ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

-Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, урт хугацааны төлөвлөлт, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан сайжруулах дагуул хотуудын хөгжлийг дэмжих стратегийг хэрэгжүүлэх,

-Инженерийн шугам сүлжээг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх шинэчлэлт, өргөтгөлд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,

-Барилгын бүсэд амын дэд бүтцийн шаардлагыг чангатгах,

САНХҮҮЖИЛТИЙН ХҮНДРЭЛИЙГ БАГАСГАХ

-Барилгын салбарт зориулсан тусгай санхүүжилтийн сан байгуулах,
-Барилгын салбарт зориулсан урт хугацааны, бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх,
-Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах татварын хөнгөлөлтийн механизм бий болгох,

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮНИЙН ӨСӨЛТ БА ИМПОРТЫН ХАМААРЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

-Дотоодын барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих татварын хөнгөлөлт бий болгох,
-Орон нутгийн түүхий эдэд суурилсан барилгын материалын судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих
-Барилгын материалын импортын гаалийн татварын бодлогыг оновчтой болгох
-Барилгын материалын ханган нийлүүлэлт, тээвэрлэлтийн сүлжээ, нөөцлөлтийн системийг боловсронгуй болгох
-Барилгын материалын үнийн индексийг тооцож, мониторинг хийх систем нэвтрүүлэх

МЭРГЭЖЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

-Барилгын салбарын мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулах
-Гадаад технологи, туршлагыг судлах, нэвтрүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
-Барилгын компаниудын дотоод сургалтын тогтолцоог хөгжүүлэх татварын урамшуулал бий болгох
-Гадаадад суралцсан мэргэжилтнүүдийг эргэн ирж ажиллахыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх

БАРИЛГЫН ЧАНАР БА АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР

-Барилгын хяналт шалгалтын тогтолцоог шинэчлэх, хариуцлагыг чангатгах, төрийн



байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах,
-Барилга байгууламжийн чанарын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх,
-Амины орон сууц, орлогод нийцсэн орон сууцны стандартуудыг боловсруулж батлах, мөрдөх,
-Газар хөдлөлтийн даацын шаардлагыг чангатгах, хяналтыг сайжруулах,
-Эрчим хүчний хэмнэлттэй барилгын стандартыг нэвтрүүлэх, ногоон барилгын технологи нэвтрүүлэгч компаниудад татварын хөнгөлөлт үзүүлэх,
-Байгаль орчинд ээлтэй барилгын материалын судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих,
-Барилгын дулаан алдагдлыг бууруулах төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
-Барилгын зөвшөөрөл олгох цахим системийг боловсронгуй болгох, төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх,

МОНГОЛ УЛСАД “БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМ”-ЫГ МБҮА ТББ НЬ БНХАУ-ЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭЛЭГЧДИЙН НИЙГЭМЛЭГ (CHINCA)-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР САНАМЖ БИЧИГ ҮЗЭГЛЭЛЭЭ



Монгол Улс, БНХАУ-ын хооронд эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, барилга, дэд бүтцийн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Барилга, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын форум-2025” арга хэмжээг 2025.09.18-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа.
Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь БНХАУ-ын Олон улсын гэрээлэгчдийн нийгэмлэг (CHINCA)-тай албан ёсны хамтын ажиллагаагаа эхлүүлж “САНАМЖ БИЧИГ” зурснаар жил бүр CHINCA&MNCA форум, үзэсгэлэнг аль нэг улсад ээлжлэн зохион байгуулах, барилга байгууламжийн хууль, дүрэм, техникийн стандарт, салбарын хөгжилтэй холбоотой мэдээлэл солилцох, Гишүүн компаниудаа хооронд нь танилцуулах, бизнес уулзалт, B2B боломжуудын төлөвлөгөөг зохион байгуулж, хэрэгжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөрүүд боловсруулах, барилгын төслүүдэд хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглүүдэд хамтран ажиллахаар тогтлоо.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ШАДАР САЙД Т.ДОРЖХАНД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ШИНЭ ШАТАНД ГАРГАСАН ФОРУМ БОЛЛОО ХЭМЭЭН ОНЦОЛЛОО

Форумыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд Т.Доржханд нээж үг хэлэхдээ хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж буйг онцлон тэмдэглэж, энэхүү форум нь хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нээх, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах чухал алхам болохыг дурдав. Мөн Хөрөнгө оруулалт, худалдааны газраас Мэдээлэл, харилцааны хэлтсийн дарга Б.Зандан "Хөрөнгө оруулалтын орчин ба нөхцөл" сэдвийн хүрээнд танилцуулга хийлээ. БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь



Миньжуань хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа батжин бэхжиж, стратегийн түншлэлийн хүрээнд шинэ шатанд гарч байгаад талархал илэрхийлэв.

БАРИЛГЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН, ФОРУМЫН АЧ ХОЛБОГДОЛ

Монгол Улсын 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр Дотоодын нийт бүтээгдэхүүн 80.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.5 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлт тогтвортой үргэлжилж байгааг илтгэж байна. Энэ өсөлтөд барилгын салбар 0.3 нэгж хувийн хувь нэмэр оруулсан бөгөөд салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх



хэмжээ 3.3 хувьд хүрсэн нь барилгын салбар нь эдийн засгийн бүтцэд чухал байр суурь эзэлж байгааг;Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд 1990-2024 оны хооронд Монгол Улсад нийт 48.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орсон бөгөөд үүнээс барилгын салбар 2.0 хувийг эзэлж, ойролцоогоор 1.0 тэрбум ам.долларыг бүрдүүлжээ. 2011-2024 оны хооронд тус салбарын жилийн дундаж урсгал хөрөнгө оруулалт 65.8 сая ам.долларт хүрсэн нь салбарын хөрөнгө оруулалтын орчин тогтвортой, өсөлттэй байгааг;

Хөдөлмөрийн зах зээлийн хувьд 2024 онд барилгын салбарт ажиллагсдын тоо 93,165-д хүрч, өмнөх оноос 13.5 хувиар өссөн нь нийт ажиллагсдын 6.9 хувийг эзэлж байна. Эдгээр макро эдийн засгийн үзүүлэлтүүд нь Монгол Улсад барилгын салбарын эдийн засагт эзлэх байр суурь, хөрөнгө оруулалтын чадавх, хүний нөөцийн хөгжил тогтвортой өсөж байгааг нотолж байна. Ийм нөхцөлд зохион байгуулагдсан Монгол, Хятадын “Барилга, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын форум-2025” нь хоёр орны бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдад бодит мэдээлэл, боломжийг олгох, салбарын хөгжилд шинэ хөшүүрэг болох чухал арга хэмжээ боллоо.





ФОРУМД БНХАУ-ЫН ДЭЛХИЙН ШИЛДЭГ 500-Д БАГТДАГ ГАДААДАД ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИД, ГҮЙЦЭТГЭГЧИД, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ОРОЛЦЛОО



Форумын арга хэмжээг хүндэтгэн Монгол Улсын томоохон бүтээн байгуулалтад оруулж буй хувь нэмэр, хамтарсан төслүүдийн үр дүн амжилттай явагдаж байгааг Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхэт Элчин сайд Н.Энхболд мэндчилгээ илгээсэн бол МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгч Фан Чючэн нар хамтын ажиллагааны ололтыг шинэ шатанд гаргасанд таатай байгаагаа илэрхийллээ.

Форумын үеэр БНХАУ-ын зүгээс Дэлхийн шилдэг 500-д багтдаг Хятадын хөрөнгө оруулагчид, төсөл хэрэгжүүлэгчид болох Shanghai Construction Group, China Railway Signal & Communication Co.,Ltd, China North Industries Corporation, China Machinery Engineering Corporation, Beiben Trucks Group Co.,Ltd, Shaanxi Construction Engineering Corporation гээд 150 гаруй компаниуд өөрсдийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг танилцуулахаас гадна Монгол Улсад өрнөж буй бүтээн байгуулалтын томоохон төслийн мэдээлэлтэй танилцлаа.

Форумын үеэр Монгол Улсад өрнөж буй бүтээн байгуулалт, хөрөнгө орчны талаар ХББОСЯ-наас "Монгол Улсын Барилга, барилгын материал дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтын орчин, боломж", Нийслэлийн "24 Мега төсөл"-ийн өнөөгийн байдал, Хүннү хотын захиргаанаас Хүннү хот төсөл, Хөрөнгө оруулалт, худалдааны газраас "Хөрөнгө оруулалтын орчин ба нөхцөл", БНХАУ-ын Төмөр замын дохиолол, харилцаа холбооны корпорацийн үйлдвэрлэлийн давуу талыг ашиглан Монголын төмөр замын тээврийн шинэ хөгжлийг дэмжих нь, МБҮА ТББ-иас "Монгол Улсын барилгын зах зээлд нэвтрэх боломж, нөхцөл шаардлага" илтгэлүүдийг тавилаа.

Харин дараагийн хэсэгт хувийн хэвшлийн томоохон төлөөллүүд болох Номин констракшн деволмент групп ХХК "NCD Group-Хөрөнгө оруулалтын төслүүд", Гурван бухат групп "Арга билиг", Барилгачин групп "Монгол Хятадын барилгын материалын худалдааны гүүр", Ай Ди Си Ай групп "Улаанбаатар хотод хүн төвт амьдралын шинэ эринийг цогцлоохуй" зэрэг томоохон төслүүдийг



хөрөнгө оруулагчдад танилцуулж, мэдээлэл солилцлоо

ХҮНДЭТГЭЛИЙН ХҮЛЭЭН АВАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Форумын хүрээнд зохион байгуулагдсан цуврал арга хэмжээний хүндэтгэлийн хүлээн авалтыг МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэгийн Ерөнхийлөгч Фан Чючэн нар нээсэн бөгөөд хоёр улсын хүндэт зочдод Монголын Үндэсний урлагийн үзвэрүүдээс толилууллаа. Мөн дараагийн өдөр Монгол Улсад хүрэлцэн ирсэн CHINCA-ийн зочид төлөөлөгчдийг ЧИНГИС ХААНЫ музейгээр зочлуулж их хааны хөрөг сэнтий, түүх дурсгалтай танилцууллаа.

ДҮГНЭЛТ, ҮР НӨЛӨӨ:

БНХАУ болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төр, аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн барилга, дэд бүтэц, эрчим хүч, тээвэр ложистик , техник технологи зэрэг салбарын хамтын ажиллагаа, түншлэл, төсөл танилцуулах, стратегийн түншлэл, бизнес хэлэлцүүлэг өрнүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилготой БНХАУ-ын Инженер, Технологийн 19 дэх удаагийн үзэсгэлэнг “Монгол, Хятадын Барилга, Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Форум-2025”-ыг 2025.09.18-20-ны өдрүүдэд МБҮА ТББ-ын Ажлын алба, Гишүүн байгууллагууд, Спонсорууд, дэмжин зохион байгуулагч ХББОСЯ, Нийслэлийн Төслийн удирдлагын газар, Хөрөнгө оруулалтын газар зэрэг байгууллагуудын олон талт хамтын ажиллагааны хүрээнд амжилттай зохион байгуулан өндөрлүүллээ.

МБҮА ТББ нь 2010 оноос хойш БНХАУ-ын Олон Улсын Гэрээлэгчдийн Нийгэмлэг (CHINCA)-тай харилцаа тогтоож өнөөдрийг хүртэл хоёр улсын хувийн хэвшлийн барилгын аж ахуйн нэгжүүдийг холбох, хамтын ажиллагааг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд жил бүр тус байгууллагаас зохион байгуулалдаг “ОЛОН УЛСЫН ДЭД БҮТЭЦ, БАРИЛГЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ” форумд гишүүн байгууллагуудаа хамруулах, хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өгөх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Ийнхүү энэхүү хамтын ажиллагаа нь дотоодын барилга, дэд бүтцийн компаниудаа олон улсын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлээд зогсохгүй, гадаадын хөрөнгө оруулалт, дэвшилтэт технологийг нутагшуулах замаар салбарын орчин үеийн хөгжил, чадавхыг дээшлүүлэхэд анхаарч төсөл хэрэгжүүлэгч компаниудын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх шинэ боломжийг нээж өгч байгаа томоохон арга хэмжээ боллоо.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ LICENSE.MN СИСТЕМД БУЮУ E-MONGOLIA-Д 2025.09.05-НЫ ӨДРӨӨС БҮРЭН ШИЛЖҮҮЛЛЭЭ

Барилгын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг license.mn системд буюу E-mongolia-д 2025.09.05-ны өдрөөс шилжүүлсэн бөгөөд ингэснээр тусгай зөвшөөрөл авахад дунджаар 21 хоног зарцуулдаг байсан бол 3 хоногт багтаан тусгай зөвшөөрлийг авах боломжууд бүрдэж байна.

БҮАТЗ хүсэгчийн ААНБ-ын mcis.gov.mn хүсэлт явуулах хүсэлтийн эрхийг хаасан бөгөөд Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn цахим системээр 2025.09.05-ны өдрөөс авдаг болсон.

ДЭЭРХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

“ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ-ӨӨРЧЛӨЛТ ШИНЭЧЛЭЛТ-2024”-ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙЛЭЭ

МБҮА ТББ нь “Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх тухай” Засгийн газрын 2014 оны 08 дугаар сарын 07-ний 250 дугаар тогтоолын хүрээнд салбарын /7/ ТББ-ууд түншилж, 2018 оноос “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг эрхлэх хуулийн этгээдэд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэж эхэлсэн нь салбартаа төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны САЙН ЖИШИГ болж, Дэлхийн банкны 2019 оны “DOING BUSINESS” индексийн үзүүлэлтээр

Монгол Улсын БҮАТЗ олгох үйл ажиллагаа нь дэлхийн 190 орноос 29-р





байранд ЭРЭМБЭЛЭГДСЭН юм. Энэ нь БҮАТЗ олгох эрхийг ТББ-д шилжүүлснээр БИЗНЕСИЙН ОРЧИН сайжирсныг илтгэсэн үзүүлэлт болсон бөгөөд 2019 онд БҮАТЗ олгох үйл ажиллагааг хагас цахимжуулж 2021 оноос бүрэн цахимжуулж төрийн үйлчилгээний ХУР, ДАН, И-МОНГОЛ системүүдтэй холбож, барилгын салбарын нэгдсэн мэдээллийн санг бий болгон холбосон. Энэ систем нь хүний оролцоогүй, ил тод, нээлттэй, түргэн шуурхай үйлчилгээтэй, аливаа дундын зуучлалгүй, салбарын инженер, техникийн ажилтнуудын статистик тоон үзүүлэлтийг нэгтгэсэн, ХҮНД СУРТАЛ, АВЛИГААС АНГИЖРУУЛСАН СИСТЕМ-ийг Монгол Улсад

нэвтрүүлснээрээ онцлог, давуу талтай болсон юм.

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛАГУУДАД БҮАТЗ-ИЙН ХҮСЭЛТ НЬ БУЦААГДАЖ БАЙГАА НИЙТЛЭГ ЯМАР ШАЛТГААНУУД БАЙГААГ ТОДРУУЛАХАД:

- ХАБЭА ажилтан шаардлага хангахгүй
- ХАБЭА-н гэрчилгээний хугацаа шаардлага хангахгүй
-ХАБЭА-н ажилтан бэлтгэх 124 цагийн сургалтад хамрагдсан байх (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/173 дугаар тушаал, "ХАБЭА-н сургалт явуулах болон шалгалт авах журам")
-Инженер техникийн мэргэжил боловсролтой, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх/
-Байгууллагын, тоног төхөөрөмжийн, гүйцэтгэсэн ажлын мэдээлэл, Нормчлолын сан төлөлтийн мэдээлэл дутуу оруулах
-ИТА давхцал, боловсролын мэдээлэл дутуу оруулах
- НДШ, тайлан дутуу оруулах
-ПРОГРАММ-д оруулсан мэдээллээ шууд засах, буцаах боломжгүй учир хүсэлт илгээсний дараа буцааж байж засдаг
-Үйлчилгээний хураамж төлөөгүй гэх мэт олон шалтгаануудаас буцаагддаг учир энэ талаар маш сайн нягталж байж мэдээллээ оруулдаг байвал та нэг удаагийн үйлдлээр бүртгэлээ албажуулж чадна.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ БАЙГУУЛЛАГУУД ЯМАР ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭДЭГ ВЭ?

-Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох асуудлыг гэрээний үндсэн дээр хариуцагч, барилгын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын хооронд байгуулсан гэрээ-ний үүргээ биелүүлээгүй бол хэрхэн хариуцлага тооцох нь тодорхой бус
-Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ -д хариуцлага тооцдоггүй
-Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын гүйцэтгэх удирдлага нь мэргэжлийн бус байснаар хууль дүрэм зөрчих, чанаргүй барилга барих, ИТА-аар ёс зүйгүй үйлдэл хийлгэх, ажилчдын цалин НДШ төлөхгүй байх, ХАБЭА дүрэм журам зөрчих зэрэг зөрчил гаргах
- Зарим ААНБ орон сууцны захиалга авч иргэдийг хохироох, туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгчдийн төлбөр тооцоо барагдуулахгүй байх
- Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцох тогтолцоо байхгүй гэх мэт түгээмэл зөрчлүүд гарч байна.

ТИЙМЭЭС ДЭЭРХ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ОЛОН ТАЛУУДЫН САНАЛЫГ СОНСОЖ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЖ, ХУУЛЬ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГА ТУЛГАРЧ БАЙНА.

-Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэгдэн хэрэгжсэн тул Барилгын тухай хууль, БҮАТЗ-ийн журамд өөрчлөлт оруулах
-БҮАТЗөвшөөрлийг шатлалгүй шаардлага хангасан ААНБ-д олгодог болгох
-ХАБЭА ажилтан барилгын инженер техникийн ажилтан суурьтай байхыг хасах, цаашид Барилгын ХАБЭА ажилтан бэлтгэдэг болох
-Бусад салбарын болон гадаадын мэргэшлийн зэргийг МУ-ын барилгын салбарын мэргэшлийн зэрэгт дүйцүүлэн тооцох
-Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын Гүйцэтгэх удирдлага мэргэжлийн биш бол Барилгын менежмент сургалтын 3 багц сургалтад хамруулах
- ИТА шилжилт хөдөлгөөн, ААНБ-ын тайлан хүлээн авах үйл ажиллагааг ТББ-д шилжүүлэх
- БҮАТЗ-ийн программ хангамжийг шинэчлэн сайжруулах, Гэрчилгээ, гэрээг цахимаар олгодог болгох
-Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм журам зөрчигчдөд хариуцлага тооцох тогтолцоог бий болгож хуулийн хэрэгжилтийг хангах

2024.10.25-2025.10.25

АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДАВ



ХББОС-ын Сайдын 2024.12.16-ны 126 дугаар тушаалаар байгуулагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл угсралт засвар үйлчилгээний хөлс тогтоох, хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулах" хүрээнд ажиллах Ажлын хэсгийн хурал 2025.01.07-ны өдөр ХББОСЯ-ны хурлын танхимд боллоо. Энэ удаагийн хурлаар Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудтай танилцахын зэрэгцээ цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцлоо.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН УУЛЗАЛТ, АРГА ХЭМЖЭЭ



ТҮНШЛЭГЧ ТББ-УУДЫН УДИРДЛАГУУДЫН 2025 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ХИЙЛЭЭ

2025.01.03-ны өдрийн ээлжит хурлаар ХББОСЯ-аас Сайдын 126 тушаал гарсантай холбоотойгоор түншлэгч байгууллагуудын байр суурь, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөлд шаардлагад оруулах саналын талаарх хэлэлцлээ. Тус хурлаар Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийг хэлэлцүүлэх, хэрэгжилтэд хяналтыг тавьж, үр дүнг танилцуулах, цаашид хийх ажлын талаар хэлэлцэв.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖЛЫН ТӨРӨЛ, СУУРЬ НӨХЦӨЛ ШААРДЛАГЫГ ААН-д ХҮНДРЭЛГҮЙ, ЧИРЭГДЭЛГҮЙ БАЙХААР ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайдын 126 дугаар тушаалын дагуу байгуулагдсан “Ажлын хэсэг”-т МБҮА ТББ оролцож ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд 2025.01.14-ны өдөр бусад ТББ болон ААНБ-ууд болоод Гишүүн байгууллагуудын саналыг сонсох уулзалтыг зохион байгууллаа.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН УУЛЗАЛТ, АРГА ХЭМЖЭЭ









БҮАТЗ-ИЙН ГЭРЧИЛГЭЭГ ГАРДУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО

Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг иргэд аж ахуйн нэгж авахад гарч буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, журамд өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийн заалтыг хөнгөвчлөх тал дээр салбарын яамтай нягт хамтран ажиллаж байгаа талаараа шинээр тусгай зөвшөөрөл авч буй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллүүдэд танилцуулан тэдний санал бодлыг сонсон цаашид үйл ажиллагаандаа тусган ажиллахаа МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Б.Батсүх онцолсон юм. Мөн шинээр барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч буй аж ахуйн нэгжийн төлөөлүүдэд гэрчилгээг нь гардуулан өглөө.

БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ШАТ ДАМЖЛАГЫГ БУУРУУЛАХ ТУХАЙ

2018 оноос эхлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбооноос барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгодог болсон. Гэсэн ч барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авахын тулд маш олон шат дамжлагыг дамжих шаардлагатай тулгарч байгаа тул БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ШАТ ДАМЖЛАГЫГ БУУРУУЛАХААР ажиллаж байгаа талаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх мэдээлэл өглөө.

БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ШАТ ДАМЖЛАГЫГ БУУРУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА

“Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн журам, суурь нөхцөл шаардлагад оруулж буй өөрчлөлт, шинэчлэлт” олон нийтийн хэлэлцүүлэг болж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ийн Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар оролцож мэдээлэл хүргэлээ.

2024.10.25-2025.10.25

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД

ХИЙГДСЭН УУЛЗАЛТ, АРГА ХЭМЖЭЭ



"Интеллект групп" ХХК, МБИХ-той хамтран зохион байгуулсан "BDCM 2025: Барилгын салбарын бизнес хөгжүүлэлт" хурлаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нь: ХББОСЯ- аас олгодог Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, Барилга ажил гүйцэтгэх, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг license.mn зөвшөөрлийн нэгдсэн системээр дамжуулан олгохоор болсон талаар болон Монгол Улсад тусгай зөвшөөрөл, эрх зүйн баримт бичиг, зөвшөөрөл шаардах үйл ажиллагааг нэг цонхоор цахимаар шийдвэрлэх зорилготойгоор хөгжүүлсэн нэгдсэн системийн давуу тал, шинэчлэлтийг бий болгоод байгаа талаараа танилцууллаа.



Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын тухай хууль өргөн баригдахтай холбогдуулан салбарын инженерүүд, төлөвлөгчид, төсөвчид, зураг төслийнхөн хуульд өөрчлөлт оруулах саналуудаа нэгтгэх зорилгоор “БАРИЛГЫН САЛБАРЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД” цуврал уулзалтад "БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЭЗЭМШИГЧДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САНАЛ ШИЙДЭЛ"-Г МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх танилцууллаа.



Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулахад хамтарсан түншлэгч мэргэжлийн холбоодын хурлаар тусгай зөвшөөрлийн шинэ системийн талаар мэдээлэл өглөө.

БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ШИНЭ ЖУРАМ ХЭРЭГЖИЖ ГЭРЭЭГЭЭ БАТАЛГААЖУУЛЛАА

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Зөвшөөрлийн зөвлөлөөс улс даяар олгогдож буй тусгай зөвшөөрлүүдийг нэгдсэн нэг системээр олгож эхлэх шийдвэр гаргасан. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг ирэх 06-р сарын 10-аас эхлэн license.mn системээс авах боломжтой боллоо.

Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn нь Монгол Улсад тусгай зөвшөөрөл, эрх зүйн баримт бичиг, зөвшөөрөл шаардах үйл ажиллагааг нэг цонхоор цахимаар шийдвэрлэх зорилготойгоор хөгжүүлсэн бөгөөд барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг нэгдсэн системээр олгодог болсноор дараах давуу тал, шинэчлэлтийг бий болгоод байна.

1. Энэ системд шилжсэнээр цахимаар гэрээ байгуулж цаг хугацаа хүний оролцоогүй болгож автоматжуулсан.
2. Шинэ системээр QR code бүхий нууцлалтай цахим гэрчилгээг системээр дамжуулан авах боломжтой болсон. Мөн хаяж гээж үрэгдүүлэх, алга болгох зэрэг асуудлыг хөнгөвчлөн шийдэж тусгай зөвшөөрлийн шийдвэрлэлт ил тод, нээлттэй боллоо.
3. Өмнө нь инженер техникийн ажилтан нь давхцалаа шалгуулах, аль байгууллагад бүртгэлтээ эсэхээ мэддэггүй байдал үүсдэг, бусад байгууллагаас хамааралтай байсныг болиулж Инженер техникийн ажилтан /ИТА/ зөвхөн өөрийн нэгдсэн нэвтрэлтээр орж бүртгэлээ хаана байгааг шууд шалгах боломжтой болсон.
4. Инженер техникийн ажилтны шилжилт тухайн аж ахуйн нэгж байгууллага өөрөө хасдаг байдлыг бий болгосон нь тухайн компанийн хариуцлагыг нэмэгдүүлж байна.
5. Тухайн аж ахуйн нэгж бүртгүүлсэн и-мэйл хаягаа мартсан бол гуравдагч байгууллагад албан бичгээр хандан и-мэйл хаягаа авдаг, солиулдаг хүний оролцоотой цаг зав зарцуулдаг байсныг болиулж иргэн төрийн нэгдсэн мэдээллийн сандаа нэвтрээд имэйл хаяг бүртгэлтэй утсаараа дамжуулаад имэйл хаягаа авах боломжтой болсон.
6. Зөвшөөрөл олгох үйл явц ил тод нээлттэй болж, иргэд болон байгууллагууд хяналт тавих боломжтой болж байна.
7. Цаг хугацаа хэмнэж бүх материалыг онлайнаар бүрдүүлэх, илгээх боломжтой болсон тул оочер дараалал, цаас, бичиг баримт, хэвлэмэл материал, тээвэрлэлт, ажилчдын илүү цаг гэх мэт нэмэлт зардлууд буурна.
8. Шийдвэр гаргах хугацаа тодорхой, хурдан болно.
9. Иргэдийн хувьд ажил, амьдралын хуваарьт саад учруулахгүйгээр хүсэлтээ гаргах боломжтой.
10. Хүсэлт өгсөн, шийдвэрлэсэн төлөв, шат бүрийг иргэн өөрөө хянах боломжтой.
11. Цахим систем нь 24/7 ажиллах тул хүссэн цагтаа үйлчилгээ авах боломжтой.

📌Тус системд шилжсэнээр төрийн байгууллагын хувьд дараах давуу талууд үүсэж байна Үүнд:

1. Тус систем нь төрийн мэдээллийн нэгдсэн сантай уялдаж байгаа тул зөвшөөрөлтэй бүх компаниудын мэдээлэл төвлөрч, хяналт, шинжилгээ хийхэд хялбар болно.
2. Тусгай зөвшөөрөл олгоход хүний оролцоог багасгаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид үйлчилгээ үзүүлэх боломжтой болно.
3. Шийдвэр гаргалт, хяналтын процесс бүртгэгдэж үлддэг тул авлига, хүнд суртал буурна.
4. Төрийн үйлчилгээний тоо, чанар хүртээмж нэмэгдэж, ил тод, нээлттэй байдал сайжирна.
5. Төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явц болон үзүүлж байгаа үйл ажиллагаанд цахим хэлбэрээр оролцох боломж нэмэгдэнэ.
6. Хяналт, шалгалт үр дүнтэй болно.
7. Эрсдэлтэй байгууллагуудыг эрэмбэлэх, анхаарал хандуулах боломж бүрдэнэ.

Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг ирэх 06-р сарын 10-аас эхлэн license.mn системээс авах боломжт

МЕГА ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

МЕГА ТӨСЛҮҮДЭД МОНГОЛЫН БАРИЛГЫН САЛБАРЫНХАН ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?



Монгол Улсын Засгийн газрын зүгээс ирэх 2025 онд үндэсний орон сууцжуулалтын бодлого, хот төлөвлөлт, бүтээн байгуулалт, ипотекийн зээлийн хүрээнд томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхээр болж байгаа бөгөөд Монголын Барилгын Гүйцэтгэгч Байгууллагуудын Холбооны зүгээс улс орны бүтээн байгуулалтад чухал үүрэгтэй гүйцэтгэгч байгууллагуудад тулгарч буй сорилтууд болон тус төслүүдийн хүрээнд төр болон хувийн хэвшил хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хэлэлцүүлэг зохион байгууллаа. Монгол Улсын хувьд нийт өрхийн 30 хувь нь орон сууцанд, 70 хувь нь инженерийн дэд бүтэцгүй байшин хороолол, гэрт амьдарч байна. Монгол Улсын Засгийн газар Үндэсний орон сууцны хөтөлбөрийн хүрээнд 150,000 орон сууц барихаар төлөвлөж байгаа бөгөөд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, гүйцэтгэгчдийг оролцуулахаар уулзалтууд хийгээд байна. Иймд тус мега төслүүд хэрэгжихэд барилгын компаниуд хэрхэн оролцох вэ? Мега төслүүд хэрэгжүүлэхээр Гадаадын хөрөнгө оруулалт төслийн менежменттэй компаниуд орж ирэхэд Монголын компаниуд бэлэн байна уу? Мега төслүүдийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчин, барилгын норм ба дүрэм стандартууд шаардлага хангах уу? Эрчим хүч, дэд бүтэц, хүний нөөц, барилгын материал, түүхий эд, тээвэр ложистик зэрэг нөөцүүдийг хэрхэн шийдвэрлэх вэ?зэрэг асуудлаар хэлэлцэж хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлаа. Энэ уулзалтад барилгын салбарын ТББ-ууд, ААНБ-ууд, экспертүүд болоод МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болон удирдах зөвлөлийн гишүүдийн төлөөллүүд оролцож саналаа солилцлоо.

ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ НЭГЖТЭЙ МБҮА ТББ АЖИЛ ХЭРГИЙН УУЛЗАЛТЫГ ХИЙЛЭЭ



МБҮА ТББ нь Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран ажиллах хүрээнд удаа дараагийн уулзалтуудыг хийж байгаа бөгөөд 2025.04.14-ны өдрийн уулзалтаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар нар дараах асуудлыг хөндлөө.

Уулзалтаар төслөөс хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдэд Фидик-ийн гэрээний зарчмыг тусгах, төслийн нэгжийн ажилтнуудыг Фидик-ийн сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх, төслийн үйл явцын мэдээлэл болоод бусад арга хэмжээнүүдэд МБҮА ТББ-ын Гишүүдийг хамруулах зэрэг олон талт хамтын

ажиллагааг хэрэгжүүлэх, хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮД ДЭЭР МОНГОЛЫН БАРИЛГЫН КОМПАНИУД ХЭРХЭН ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГУУДТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



Олон улсын геополитик, худалдааны дайн нь хөрш орны болон дотоодын эдийн засгийн нөхцөл байдалд муугаар нөлөөлж байгаа энэ үед дотоодын барилгын салбарын ААН, компаниудыг дэмжих бодлого нэн шаардлагатай байгаа болон 2025-2028 онд нийслэлд хэрэгжих Сэлбэ дэд төв, Туул хурдны зам зэрэг барилга бүтээн байгуулалтын төслүүдэд дотоодын барилгын компаниуд ерөнхий гүйцэтгэгчээр оролцох боломжийг бүрдүүлж, тухайн ажлыг хэсэгчлэн хуваан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх талаар зөвлөмж гаргаснаа Нийслэлийн удирдлагууд болоод холбогдох яаманд албан бичиг хүргүүлсэн юм.

Уг асуудлын хүрээнд 2025.05.12-ны өдөр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Удирдах зөвлөлийн гишүүд, Монголын Барилгачдын Нэгдсэн Холбооны Ерөнхийлөгч Ч.Наранбаатар болоод бусад барилгын компанийн захирлууд Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай болоод Төслийн Нэгдсэн удирдлагын нэгжийн удирдлагуудтай санал солилцлоо.

Учир нь МБҮА ТББ нь барилгын Гэрээлэгчид, хөрөнгө оруулагчид, ханган нийлүүлэгчид, зураг төсөл зохиогчид гээд Монгол Улсын барилга үл хөдлөхийн салбарын 250 гаруй аж ахуй нэгж байгууллагуудын нэгдэл бөгөөд сүүлийн 30 жилийн хугацаанд барилга орон сууц, үл хөдлөхийн томоохон төслүүдийг амжилттай хийж гүйцэтгэж ирсэн төдийгүй Улаанбаатар хотоос зарлан хэрэгжүүлэх гэж буй барилга орон сууцны төслүүдийг дотоодын аж ахуйн нэгжүүдийн хүчээр гүйцэтгэх хүн хүч, технологи, төслийн удирдлагын бүрэн чадамжтай гэдгээ илэрхийлээ.

Харин Нийслэлийн удирдлагуудын зүгээс Нийслэлд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд болоод цаашид аж ахуйн нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, багц хөтөлбөрүүдийн талаар танилцууллаа. Мөн дараагийн багц төслүүдийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн өөрчлөлт, төрийн зүгээс барьж буй бодлого, инженерийн мэргэжлийг сурталчлах, Фидик-ийн гэрээн дээр хамтран ажиллах зэргээр шат дараалсан уулзалтуудыг хийх, “Ажлын хэсэг” байгуулах замаар хамтран ажиллах боломжтой талаар санал солилцлоо.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ДОТООДЫН КОМПАНИУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД БОЛОН БУСАД ЧИГЛЭЛЭЭР НИЙСЛЭЛТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО

Нийслэлээс хэрэгжүүлж буй төслүүдэд дотоодын барилгын компаниудад ерөнхий гүйцэтгэгчээр оролцох боломжийг бүрдүүлж, тухайн ажлыг хэсэгчлэн хуваан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх талаарх зөвлөмж гаргаснаа МБҮА ТББ нь Нийслэлийн удирдлагууд болоод холбогдох яаманд албан бичиг хүргүүлж улмаар шат шатны уулзалтуудыг хийсэн билээ.



Уг асуудлын хүрээнд 2025.05.16-ны өдөр МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан тэргүүтэй Удирдах зөвлөлийн гишүүд, Гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүтээн байгуулалтыг хийж буй компанийн захирлууд Нийслэлийн Засаг Даргын Эдийн Засгийн Хөгжил, Дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Сэлбэ дэд төвийн дарга У.Баатар нартай "Санамж бичиг" үзэглэлээ. Талууд:

Олон Улсад хүлээн зөвшөөрөгдсөн инженеринг, барилгын гэрээний жишиг нөхцөлийг орчуулах, нутагшуулах, хэрэглэхтэй холбоотойгоор мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, хамтарсан санаачилга гаргах, шаардлагатай төсвийг тусгах чиглэлээр хамтран ажиллана;

Хөгжлийн төслүүдийн хүрээнд дотоодын компаниудын оролцоог хангах, давуу эрхийг үнэлгээнд тусгах, оролцох боломжоор хангах арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлнэ;

Барилга, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, эрчим хүч, худалдан авах ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллана;

Инженер, техникийн мэргэжлийг олон нийтэд сурталчлах, оюутан, суралцагчдыг дэмжих, нийслэлийн хөгжлийн төслүүдэд инновац, тэвшилтэт технологийг нэвтрүүлэх санал гаргах, хэрэгжилтэд нь хамтран оролцох чиглэлээр талууд харилцан дэмжиж ажиллах чиглэлээр “Санамж бичиг”-т тусгагдсан чиглэлүүдээр нийслэлийн хэрэгжүүлж буй томоохон төслүүдийн хүрээнд хамтран ажиллахаар боллоо.

Улмаар санамж бичигт зурсан ажлуудыг ажил хэрэг болгохоор “Ажлын хэсэг”-ийг газар дээр нь байгуулан эрчимжүүлэхээр тохирлоо.

СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ТЕНДЕРТ МОНГОЛ КОМПАНИ ОРОЛЦОХ БОЛОМЖГҮЙ АСУУДЛААР ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД ГОМДОЛ ГАРГАЛАА



Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын бүтээн байгуулалтын тендерт ганц ч Монгол компани оролцох боломжгүй нөхцөл тавиад хуулийн дагуу 2025.05.30-ны өдрийн дотор бүрдүүл гэх шаардлага тавьж байгаа нь техник өгөгдлийн буюу тендерийн худалдах авах ажиллагааны баримт бичигт сүүлийн таван жилийн борлуулалтын орлогоос аль нэг жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх гэсэн өндөр босго

тавьсан байна.Тухайлбал Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын төсөвт өртөг нь нийтдээ 840 тэрбум төгрөг, багц болгож хуваасан хэдий ч хоёрдугаар багц нь л гэхэд жилийн 136 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байхыг шаарджээ. Өнөөдрийн нөхцөлд Монгол Улсад ийм хэмжээний орлоготой хувийн компани маш ховор. Нөгөө талаас энэ нь Монгол Улсын хуулийн этгээд, аж ахуй нэгж ажилтай, орлоготой байхын эсрэг зохицуулалт болж байна. Өөрөөр хэлбэл ийм хэмжээний төсөв, өртгийн боломжийг тендер зарласнаас 5 сарын дотор материалаа бүрдүүлж өгнө гэдэг бол Монгол Улсын Хуулийн этгээдийн хувьд асар хүндрэлтэй юм.

Уг нөхцөл шаардлагаас шалтгаалан гадаадын компаниудад давуу нөхцөл бүрдэж, дотоодын эдийн засаг, үндэсний компаниудын оролцоо хязгаарлагдаж, улсын эдийн засгийн хяналт, аюулгүй байдал алдагдах эрсдэл бий болоод байна.

Мөн Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд зааснаар төр эдийн засгийн зохицуулалт хийхдээ нийгмийн хөгжлийг хангах зорилготой байх ёстой. Гэтэл Монгол Улсын хуулийн этгээд орох боломжгүй шаардлага, бүрдүүлэхэд ч хүндрэлтэй давчуу цаг хугацаа тавигдах нь төсвийн зохицуулалт, үүнийгээ дагаад нийгмийн хөгжилд саад учруулсан Үндсэн хуулийн шаардлага зөрчсөн хуулийн зохицуулалт болж байна.

Төсвийн хэмнэлтийг зөвхөн орлого, зардлын хэмжээнд анхаарч, хэмнэлтийг хэрэгжүүлэх нь нийгмийн суурь хэрэгцээ, хүн амын амьдралын чанарыг хангахад сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, нийгмийн үйлчилгээний төсөвт хэмнэлт хийх нь тухайн чиглэлийн тусгай хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, хойшлуулах, бүр цуцлах зэрэг үр дагаварт хүргэж, улмаар төрийн зүгээс хүлээсэн нийгмийн сайн сайхны төлөөх үүрэг, зорилгыг биелүүлэхэд саад учруулж байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь хэсгүүд нь батлагдсан төсөл, арга хэмжээг богино хугацаанд багтаахыг шаарддаг бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд санхүүжилтийг хасах зохицуулалттай. Энэ нь тухайн төсөл арга хэмжээнд оролцох боломжийг хязгаарлаж, зарим тохиолдолд иргэдийн үндсэн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл үүсгэж байна.

Иймд төсвийн сахилга бат, хэмнэлтийн зорилго нь нийгмийн хөгжлийг хангах төрийн үндсэн чиг үүрэгтэй зөрчилдөхгүй, харин нийцтэй, тэнцвэртэй хэрэгжих шаардлагатай. Гэвч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн эдгээр заалтууд нь Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “эдийн засгийн зохицуулалт нь хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилготой байх” гэсэн үндсэн зарчмыг зөрчиж байна.

Мөн уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар хэмнэлт нь хүлээн зөвшөөрөхүйц байх, үр ашигтай байх, бодитой байх, өөрчлөлт шинэчлэлтийг дэмжих гэх мэт зарчмыг баримтлахыг заасан. Нөгөө талаар маргаан бүхий Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтууд нь үндсэн зорилтдоо нийцээгүй, мөн Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан Эдийн засгийн аюулгүй байдал ба Төрийн хэмнэлтийн дээр дурдсан хуулийн зохицуулалтуудын хүрээнд хэмнэлт хийх нь зөвхөн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, зардал хэмнэхэд чиглэсэн байж болох ч зарим тохиолдолд төсвийн санхүүжилт зогсох, орхигдох нь эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Жишээ нь төрийн төсөл, арга хэмжээнүүдийн үргэлжлэл болон чанарт шууд нөлөөлж болзошгүй бөгөөд энэ нь нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж, тогтвортой байдалд аюул учруулж болно.

Иймд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Үндсэн хуулийг зөрчсөн дээрх асуудлын хүрээнд иргэн Г.Батсүх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцэд өргөдөл гаргаснаа хүлээлгэн өглөө.

СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ОРОН СУУЦНЫ ТЕНДЕРИЙН БАГЦЫГ ХУВААХААР

НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГУУД ШИЙДВЭР ГАРГАЛАА

2025.06.25-ны өдрийн 09:00 цагт Сэлбэ дэд төвийн багц тендерийг хуваах, дотоодын компаниудыг хэрхэн оролцуулах тухай Нийслэлийн Засаг даргын тамгын газраас Соёлын Төв өргөөнд хэвлэлийн бага хурлыг хийлээ. Хуралд нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн Гүйцэтгэх захирал У.Баатар, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, МБНХ-ны Ерөнхийлөгч Ч.Наранбаатар нар оролцлоо. Хурлаар үндэсний компаниудыг дэмжиж дотооддоо нэмүү өртөгөө шингээх үүднээс тендерийн бичиг баримтдаа ажиллах хүчин 40%, машин техник 30% гээд бүх зүйл дээр квот тогтоож байгаа. Нийт төсөл маань 45 цагцаас бүрдэх бөгөөд 20-45 дахь багцуудад дотоодын аж нэгжүүдтэйгээ хамтрахаар байгаа. Ингээд Сэлбэ дэд төвийн багц тендерийн 3-4 багцыг 5 хуваахаар болсныг олон нийтэд мэдээллээ. *Харин МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх:* Бидний хувьд салбарын гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, эрх зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж ажилладаг. Өнгөрсөн хугацаанд бид Нийслэлийн Түгжрэлийн нэгж, Нийслэлтэй санамж бичиг байгуулж ажиллахаас гадна хэрэгжүүлж байгаа төслүүдэд Фидик-ийн гэрээний зарчмаар ажиллах, ажиллах хүчнийг мэргэшүүлэх тал дээр хамтран ажиллаж байсан. Өнгөрсөн хугацаанд хийсэн энэ их ажлуудын үр дүн минь гарч гаргасан шийдвэрийг цуцлан тендерийн багцыг хуваж байгаад баяртай байна.

Дашрамд дурдахад МБҮА ТББ нь Нийслэлээс зарласан мега төслүүдэд дотоодын барилгын компаниудыг оролцуулах боломжоор хангахын тулд Нийслэлийн удирдлагууд, төслийн удирдлагын нэгжүүд, холбогдох албаны хүмүүстэй 2024 оны 12 сараас хойш шат дараалсан уулзалт, хэлэлцүүлэг, Санамж бичиг байгуулах чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд Сэлбэ дэд төвийн 1, 2-р багцын сонгон шалгаруулалт зарласан цаг үеэс эхлэн Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн Гүйцэтгэх захирал У.Баатар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч Агентлаг Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Батцэцэг, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Амгалан нарт албан хүсэлтийг өгсөн билээ. Тухайлбал өнгөрсөн хугацаанд *МБҮА ТББ-ын зүгээс дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ:*

- 2024.12.14 түгжрэлийг бууруулах төслийн нэгжийн хэрэгжүүлэх төслүүдэд аж ахуйн нэгжүүдийг хамруулах тал дээр санамж бичиг зурлаа.
- 2025.04.12 нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатартай уулзалт хийв.
- Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн Гүйцэтгэх захирал У.Баатар Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Батцэцэг
- Нийслэлийн засаг даргын тамгын газрын дарга Д.Амгалан нарт албан хүсэлт өгөөд байна.
- 2025.05.12 Нийслэлийн 1-р орлогч Т.Даваадалай, Сэлбэ хорин минутын хот корпорац ххк-ийн гүйцэтгэх захирал У.Баатар болоод төслийн удирдлагын нэгжтэй хийсэн уулзалт хийв.
- 2025.05.16 Бүтээн байгуулалтын төслүүдэд дотоодын компаниудын оролцоог хангах ажлын хүрээнд болон бусад чиглэлээр нийслэлтэй хамтран ажиллахаар боллоо.
- 2025.05.22 Сэлбэ дэд төвийн тендерт монгол компани оролцох боломжгүй асуудлаар үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргалаа.
- Төрийн ордны гадна хугацаагүй суулт хийж буй барилгачдын нэгдсэн холбоо ТББ-иас зохион байгуулж буй суултад очиж дэмжлэг үзүүлэв
- 2025.05.28 Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх,

- УИХ-ын дарга Д.Амарбаясгалан нарт албан шаардлага хүргүүлэв
- 2025.06.03 Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээр боллоо.
- 2025.06.10 Монополын эсрэг газар албан хүсэлт өглөө
- 2025.06.12 УИХ-ын чуулганы үеэр шинэ Ерөнхий сайд Г.Занданшатар арга хэмжээ авах талаар мэдэгдлээ
- 2025.06.13 МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, МБНХ-ны Ерөнхийлөгч Г.Наранбаатар, МБГБХ Тэргүүн Ц.Эрдэнэбат нарын барилгачдын төлөөллийг Нийслэлийн Засаг даргын 1-р орлогч Т.Даваадалай хүлээн авч зөвшилцөх уулзалтыг хийлээ.
- 2025.06.15 Монополын эсрэг газарт өгсөн албан бичгийн хариуд уг асуудлыг түдгэлзүүлэн хянаж байгаагаа илэрхийлсэн хариу ирлээ.
- 2025.06.25 Тендерийг хуваах хэвлэлийн хурал болов.

ДОТООДЫН БАРИЛГЫН КОМПАНИУД БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ АСУУДЛААР ШАТ ДАРААЛСАН АРГА ХЭМЖЭЭГ АВСАНЫ ҮР ДҮНД НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГУУД ЗӨВШИЛЦӨХ УУЛЗАЛТЫГ ХИЙЛЭЭ



МБҮА ТББ нь Нийслэлээс зарласан мега төслүүдэд дотоодын барилгын компаниудыг оролцуулах боломжоор хангахын тулд Нийслэлийн удирдлагууд, төслийн удирдлагын нэгжүүд, холбогдох албаны хүмүүстэй 2024 оны 12 сараас хойш шат дараалсан уулзалт, хэлэлцүүлэг, Санамж бичиг байгуулах чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд Сэлбэ дэд төвийн 1, 2-р багцын сонгон шалгаруулалт зарласан цаг үеэс эхлэн бүх шатны түвшинд албан бичиг хүргүүлэх, санал солилцох зэргээр ажиллаж байгаа юм. 2025.06.13-ны өдөр МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, МБНХ-ны Ерөнхийлөгч Г.Наранбаатар, МБГБХ Тэргүүн Ц.Эрдэнэбат нарын барилгачдын төлөөллийг Нийслэлийн Засаг даргын 1-р орлогч Т.Даваадалай хүлээн авч зөвшилцөх уулзалтыг хийлээ.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ҮҮСГЭХЭЭР БОЛЛОО



СЭЛБЭ ДЭД ТӨВ-ийн тендерийг цуцалж дахин тендер зарлахад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалт саад болж байсан учир 2025.05.26-ны өдөр ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД өргөдөл гаргасан билээ. Нийслэлийн Худалдан

авах ажиллагааны газраас зарласан Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын бүтээн байгуулалтын тендерт ганц ч Монгол компани оролцох боломжгүй нөхцөл тавиад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2025.05.31-ны өдрийн дотор яаран тендер зарлаж байгаа нь гадаадын компаниудад давуу нөхцөл бүрдэж, дотоодын эдийн засаг, үндэсний компаниудын оролцоо хязгаарлагдах эрсдэл бий болж байна.


Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь хэсгүүд нь батлагдсан төсөл, арга хэмжээг богино хугацаанд багтаахыг шаарддаг бөгөөд хугацаа хэтэрсэн тохиолдолд санхүүжилтийг хасах зохицуулалттай. Энэ нь тухайн төсөл арга хэмжээнд оролцох боломжийг хязгаарлаж, зарим тохиолдолд иргэдийн үндсэн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл үүсгэж байна. Мөн энэ асуудлаар иргэн Б.Раднаасүрэн, Б.Бямба-Очир нар Үндсэн хууль зэрчсөн эсэх тогтоолгох шаардлага бүхий мэдээлэл ирүүлсэн байна.

Үндсэн хуулийн цэцээс уг өргөдлийг хянаж үзээд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтад “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;”, 13.1.2 дахь заалтад “энэ хуулиин 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл арга, хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4, 19.1, Долдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсүгэй хэмээн үзэж уг асуудлыг Үндсэн хуулийн дунд суудлын цэц шалган шийдвэрлэхээр боллоо.

МБҮА ТББ НЬ ДОТООДЫН БАРИЛГЫН КОМПАНИУД БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ АСУУДЛААР ШАТ ДАРААЛСАН АРГА ХЭМЖЭЭГ АВЧ БАЙНА

МБҮА ТББ нь Монгол Улсын томоохон барилга, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, үл хөдлөх хөрөнгө, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт, зураг төсөл, архитектурын чиглэлийн 200 гаруй барилгын компаниудыг эгнээндээ нэгтгэж, нийгэмдээ болон гишүүддээ үйлчилдэг, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалж,





“МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ” НҮТББ-Д

МОНОПОЛЬН ЭСРЭГ ГАЗАР

2025.05.10. № 01/1939

Хөрөнгө оруулалт тухай

Танай холбооноос 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 25/86/АА дугаартай албан бичгээр Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан “Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллол Бағц 3 (НХААГ/202501016646)” болон “Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллол Бағц 4 (НХААГ/202501016647)” зарлаг тендер шалгаруулалттууд нь Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 11 дүгээр зүйлийн 11.1.4, 13 дугаар зүйлийн 13.2.3, 13.2.5-д тус тус заасныг зөрчсөн...” гэх гомдолтой танилцлаа.

Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д “эдийн засгийн болон техникийн бодит үндэслэлгүйгээр аж ахуйн бусад харилцаа тогтоохоос татгалзах, үндэслэлгүйгээр шалгуур үзүүлэлт тогтоох;” гэж, 11.1.4-т “үрэлдэнт шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн өмчийн хөрөнгөөр барааа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, түүний нэг багц, хэсэгт харилцан хамаарал бүхий эгээдтэй хамт оролцох, эсхүл бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулах, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох.” гэж, 13 дугаар зүйлийн 13.2.3-т “түүнийг зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хоригловсон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн;” гэж, 13.2.5-д “зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн;” гэж тус тус заасан.

Дээрх хуулийн заалтуд нь давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоогдсон этгээд нөөлөх үйл ажиллагаа явуулах, эсхүл аж ахуй эрхлэгчид хоорондын өрсөлдөөнийг хязгаарлах хэлцэл байгуулах, мөн төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуульд зааснаас бусад тохиолдолд өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэр, зохицуулалт гаргасан нөхцөл байдалд хамаарах эрх зүйн зохицуулалт болно. Харин түүс гомдолд дурдсан тендер шалгаруулалтууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулагдаж байна.

Монополын эсрэг газарт сонирхогч этгээдүүдээс дээрх тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох гомдлыг ирүүлснийг Төрийн болон орон




нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйл болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу түдгэлзүүлэн хянах байгаа болно.


ДАРГА Б.БИЛГҮҮН


тэдний дуу хоолойг төрд хүргэх, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, гүүр болж ажилладаг билээ. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас зарласан мега төслүүдэд дотоодын барилгын компаниудыг оролцуулах боломжоор хангахын тулд Нийслэлийн удирдлагууд, төслийн удирдлагын нэгжүүд, холбогдох албаны хүмүүстэй шат дараалсан уулзалт, хэлэлцүүлэг, Санамж бичиг байгуулах чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал Сэлбэ дэд төвийн 1, 2-р багцын сонгон шалгаруулалт зарласан цаг үеэс эхлэн Сэлбэ хорин минутын хот корпорац ХХК-ийн Гүйцэтгэх захирал У.Баатар, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч Агентлаг Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Батцэцэг, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Амгалан нарт албан хүсэлт өгөхөөс гадна, шат шатны бүх удирдлагуудад албан хүсэлтээ өгсөөр байна

СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ОРОН СУУЦНЫ ТЕНДЕРИЙН БАГЦЫГ ХУВААХААР БОЛЛОО

Нийслэлээс зарласан мега төслүүдэд дотоодын барилгын компаниудыг оролцуулах боломжоор хангахын тулд Нийслэлийн удирдлагууд, төслийн удирдлагын нэгжүүд, холбогдох албаны хүмүүстэй 2024 оны 12 сараас хойш шат дараалсан уулзалт, хэлэлцүүлэг, Санамж бичиг байгуулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж байна. Энэ хугацаанд Сэлбэ дэд төвийн 1, 2-р багцын сонгон шалгаруулалт зарлахдаа дотоодын компаниуд оролцох боломжгүй нөхцөл шаардлага тавьсан учир МБҮА ТББ нь салбарын ТББ-уудтай хамтран Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, УИХ-ын дарга Д.Амарбаясгалан, Ерөнхий сайд Г.Занданшатар, Үндсэн хуулийн цэц, Нийслэлийн удирдлагууд, төслийн нэгж, Монополын эсрэг газар гээд шат шатны бүх төрийн өндөр албан тушаалтнууд, холбогдох яам, агентлагуудад албан хүсэлт, бичиг, шаардлагуудыг шат шатны түвшинд хүргүүлэн ажиллаж байна. Уг








ажлын хүрээнд Монополын эсрэг газарт өгсөн албан бичгийн хариуд уг асуудлыг түдгэлзүүлэн хянаж байгаагаа илэрхийлсэн хариу ирлээ.

СЭЛБЭ ХОТЫН ОРОН СУУЦЖУУЛАХ 3,4-Р БАГЦЫН ТЕНДЕРТ МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН МОНКОН КОНСТРАКШН ХХК, НУТГИЙН БУЯН ГРУПП ХХК НАР ШАЛГАРЧ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛЛОО

Сэлбэ хотын орон сууцжуулах төслийн 3, 4 дүгээр багц тендерийг задалж, тав хуваан зарласан. Уг тендерт дотоодын 17, гадаадын 17 аж ахуйн нэгж таван багц тендерт давхардсан тоогоор 64

тендерийн санал ирүүлснээс Нутгийн буян групп ХХК, Монкон констракшн ХХК, Професионалстрой ХХК, Моринсувд ХХК, China Construction Fifth Engineering Bureau тендерт шалгарлаа.

Тухайлбал:

•Багц 3.1 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 11 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “China Construction Fifth Engineering Bureau” компани,

•Багц 3.2 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 12 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Моринсувд” ХХК,

•Багц 3.3 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 14 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Нутгын буян” ХХК,

•Багц 4.1 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий 16 блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Монкон констракшн ХХК ”

•Багц 4.2 буюу Сэлбэ дэд төвийн 71 айлын есөн давхар бүхий зургаан блок болон 71 айлын 12 давхар бүхий найман блок орон сууцны иж бүрэн цогцолбор хорооллын тендерт “Професионалстрой” ХХК шалгарсан юм. Өнгөрсөн хугацаанд МБҮА ТББ нь Нийслэлээс зарласан мега төслүүдэд дотоодын барилгын компаниудыг оролцуулах боломжоор хангахын тулд Нийслэлийн удирдлагууд, төслийн удирдлагын нэгжүүд, холбогдох албаны хүмүүстэй 2024.12-р сараас хойш шат дараалсан уулзалт, хэлэлцүүлэг, Санамж бичиг байгуулах чиглэлээр ажиллаж Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гарган Монополын эсрэг газар албан хүсэлт өгч, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, УИХ-ын дарга Д.Амарбаясгалан нарт албан шаардлага хүргүүлснээр 2025.06.25 уг тендерийг хуваах шийдвэрийг гаргуулсан билээ. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд Сэлбэ хотын орон сууцжуулах төслийн 3, 4 дүгээр багц тендерийг задалж, тав хуваан зарласнаар Монгол компаниуд оролцох боломжийг олгуулсан юм.

Монгол компаниудыг уг төсөл хөтөлбөрт хамруулах тал дээр Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, орлогч дарга Т.Даваадалай, Сэлбэ хорин минутын хот ХХК-ийн захирал У.Баатар нар идэвх санаачилга гаргаж тендерийг хуваах шийдвэр гаргаж өгсөнд гүнээ талархал илэрхийлье.

Мөн уг акцад хамтран оролцсон бүх Төрийн бус байгууллагуудын удирдлага, барилгачиддаа талархал илэрхийлье.

ХҮННҮ ХОТЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО




Нийслэлийн Улаанбаатар хотын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4-т “Хүннү’ хотыг Нийслэлийн хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагууд хот болгон хөгжүүлнэ гэж батлагдсантай холбогдуулан “ХҮННҮ ХОТЫН ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ” хэлэлцүүлгийг 2025.05.01-ны өдөр Хангарди хотхонд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, “Хөшгийн хөндийн чөлөөт бүс”-ийн Захирагч Б.Саранчимэг, Хүннү хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр, Улаанбаатар хотын Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэр, Монголын Ложистикийн холбооны

Ерөнхийлөгч А.Мөнхболд нар болоод бусад албаныхан барилгын салбарынханд Хүннү хотын тээвэр логистик, Улаанбаатар 2040 хөгжлийн төлөвлөгөө, төр хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчны талаарх мэдээ мэдээллийг өглөө. Уг арга хэмжээнд МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Дэд ерөнхийлөгч Б.Нэмэхбаатар, Д.Энхтөр, Гүйцэтгэх захирал Г.Батсүх тэргүүтэй удирдлагын багийнхан бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож Хүннү хотын бүтээн байгуулалтад барилгын компаниудын оролцоог хангах, чанартай барилгын материалыг үнийн хөөрөгдөлгүй тасалдалгүй нийлүүлэхэд анхаарч ажиллах талаар саналаа хүргэлээ.

НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГУУДАД БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН









НИЙЛҮҮЛЭЛТ, ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ТАЛААРХ ТӨСЛӨӨ ТАНИЛЦУУЛЛАА

Томоохон бүтээн байгуулалтууд эхэлж байгаа энэ үед МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Г.Батсүх нь Монголын Ложистикийн холбоотой хамтран барилгын салбарын барилгын материал үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тээвэр, логистикийн сүлжээ, хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал болоод тулгарч байгаа асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх, боломж хаана байгаа вэ гэдэг талаарх төслийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Хотын орлогч Т.Даваадалай, төслийн нэгжийн захирлуудад танилцуулж санал бодлоо солилцлоо. МБҮА ТББ нь Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Монголын Логистикийн Холбоотой хамтран ажиллах санамж бичгийг байгуулан Гишүүн байгууллагуудтайгаа хамтран төсөл хөтөлбөрүүдэд оролцох, судалгаа хийх, төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үндэсний компани, үйл ажиллагаа эрхлэгчдийн эрх ашгийг бэхжүүлэх чиглэлээр харилцан санал бодлоо солилцож ойлголцолд хүрээд байгаа юм.

ХҮННҮ ХОТЫН ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН БҮС БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН БАРИЛГЫН МАТЕРИАЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ КОМПАНИУДТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО

Нийслэл Улаанбаатар хотын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүннү’ хотыг төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагууд хот болгон хөгжүүлэхтэй холбогдуулан 2025.05.27-ны өдөр барилгын материал, тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ, холбоодын төлөөлөлтэй уулзаж,



санал солилцлоо. Хурлын үеэр Хүннү хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр “Улаанбаатар хотод 2025-2028 онд 24 мега төсөл хэрэгжүүлэх талаар Хүннү хотын Хөгжлийн корпораци ХХК-ийн захирал Г.Гүнболд Хүннү хотын тээвэр логистикийн төвийг байгуулах талаарх танилцуулгыг хийж шинэ хотын бүтээн байгуулалтад ААН-үүдтэй хамтран барилгын материалын ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг цогцоор нь төлөвлөх шаардлагатай. Шинэ бүтээн байгуулалтыг төр дангаараа хийх боломжгүй учир төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шинэ хот тосгон, том төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Харин уулзалтын үеэр **МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх** “Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөөд буй томоохон мега төслүүдийг барилгын материалаар хангах шаардлага гарч байгаа. Эдгээр томоохон томоохон төсөл хөтөлбөрүүдийн барилгын материалд одоо байгаа эрэлт хэрэгцээнээс 2-3 дахин ихэснэ. Иймд барилгын материалынхаа 70 хувийг импортоор хангадаг манай улсын хувьд томоохон төслүүдээ явуулахад тээвэр логистикийн асуудал саатах эрсдэлтэй. Ийм учраас бид нийслэл болон Хүннү хоттойгоо хамтраад барилгын материалын логистикийн төвийг байгуулах асуудлаар Монголын Барилгын Үндэсний Ассоциаци, Барилгын Ханган нийлүүлэгчдийн Зөвлөл холбоод хамтран санал бодлоо солилцож, шийдэл гаргалгааны талаар танилцуулга хийлээ.

ТӨСЛИЙН МЕНЕЖЕРҮҮДИЙН ХОЛБООНООС CIVIL ENGINEERING БЭЛТГЭХ КОМПАНИТ АЖЛЫГ ӨРНҮҮЛНЭ

Нийслэлийн Засаг даргын 1-р орлогч Т.Даваадалай, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Монголын Уул Уурхайн Ассоциаци ТББ, Эрчим Хүчний Инженерүүдийн холбоо зэрэг ТББ-уудын удирдлагуудыг хүлээн авч чөлөөт уулзалт хийлээ.



Уулзалтаар бүтээн байгуулалтын салбаруудын нийгэмд үзүүлж буй нөлөөлөл, мэргэжилтэй боловсон хүчний хүрэлцээ, чадамжийн талаар ярилцаж залуу үеэ CIVIL ENGINEERING чиглэлээр суралцах хүсэл сонирхлыг бий болгох компанит ажлыг хамтран зохион байгуулахаар ярилцлаа.Барилга, дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүч, аж үйлдвэрийн эрх зүйн орчин нь тус тусдаа салангид өөр өөр ойлголтой байгаа нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд асуудал дагуулж байгаа учир салбаруудын уялдаа холбоог хөнгөлж CIVIL engineering гэсэн 1 ойлголтоор асуудалд хандаж, нэр томьёо болон эрхзүйн баримт бичгүүдээ цэгцлэх шаардлага үүсэж байна. Уг арга хэмжээнд МБҮА-ийн Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар оролцож салбарууд хамтран эрх зүйн орчноо нэгдсэн бодлоготой болгож, хамтдаа шинэчлэн сайжруулах тал дээр саналаа илэрхийлж цаашид үйл ажиллагаанд идэвхтэй хамтран ажиллахаар боллоо.

ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨГЖҮҮЛЭЛТ, СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД



ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУДАД “БИЗНЕСИЙН СТРАТЕГИА ШИНЭЧЛЭХ НЬ” СЭДВЭЭР СУРГАЛТЫГ ХИЙЛЭЭ









МБҮА ТББ-ын Гишүүн компаниудын удирдах ажилтнуудад зориулсан “Бизнесийн стратегиа шинэчлэн, OGSM аргаар төлөвлөх нь” сэдэвт сургалтыг Ганабелл Институт-тэй хамтран зохион байгууллаа. Сургалтаар залуу бизнесмэнүүдэд уламжлалт арга барилаас гадна үйл ажиллагаа, бизнесээ явуулахад юун дээр амжилт гаргаж хаана алдаа гарч байна вэ гэдгээ ахин нэг шинжлэн судлахын тулд дэлхийд нэртэй олон компаниудын алдаа, оноо, амжилт, дампуурлын жишээн дээр тулгуурлан тайлбарлалаа. Мөн компани тань нэг л урагшлахгүй, үйл ажиллагаа, борлуулалт тань санасанаар тань болохгүй байгаа бол стратегиа ахин шинэчлэн, OGSM аргаар төлөвлөөд үзэх, тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх арга барилын талаар Ганабелл Институтын багш Т.Амарсанаа онол болоод бодит кейс дээр тулгуурлан заалаа.

БАРИЛГЫН САЛБАРТ ФИДИК-ИЙН ГЭРЭЭГ НУТАГШУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ЭЭЛЖИТ СУРГАЛТЫГ ХИЙЛЭЭ

МБҮА ТББ нь Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (ФИДИК)-нд ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН-ий хувьд Монгол Улсын барилгын салбарт олон улсын гэрээ, эрх зүйн орчныг стандартын дагуу хэрэгжүүлэх, шинэ дэвшил, эргэлтийг авчрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2025.01.23-ны өдөр салбарын мэргэжилтнүүдэд “Барилгын төслийн гэрээ фидик-ийн жишиг гэрээний нөхцөл”-үүд сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар ФИДИК буюу Олон улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо, түүний үйл ажиллагааны тухай, жишиг гэрээнүүд, тэдгээрийн ялгаа, жишиг гэрээнээс хэрхэн сонгох тухай, өргөн хэрэглэгддэг Улаан, Шар болон Мөнгөлөг гэрээнүүдийн ялгаа, гэрээний бүтэц, Тусгай нөхцөл бэлтгэх зааварчилгаа, Алтан зарчим, Гэрээний



талууд, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлагын зохицуулалт, Захиалагч, Инженер, Гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлага, Ажил эхлүүлэх, хойшлох, түр зогсоох, гэрээ цуцлах зохицуулалтууд, Ажил гүйцэтгэх явцын зохицуулалтууд, Гэрээний үнэ, төлбөр, баталгаа, даатгал, Зураг төсөл, дундын болон эцсийн туршилт, ажлыг хүлээж авах, Маргаан шийдвэрлэлтийн талаарх ойлголтыг өглөө.

МБҮА ТББ НЬ "BUSINESS MEETING & ГИШҮҮДИЙН ЧӨЛӨӨТ УУЛЗАЛТ"-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ-ын Гишүүн компаниуд болон "Дулаан шийдэл II" төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хооронд бизнесийн холбоо тогтоох боломжийг олгох, салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх ярилцан, харилцан байр сууриа солилцох, талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх хүрээнд 2025.02.05-ны өдөр "BUSNESS MEETING & ГИШҮҮДИЙН ЧӨЛӨӨТ УУЛЗАЛТ"-ыг зохион байгууллаа. Тус уулзалтад Гишүүн компаниуд болон дулаан шийдэл төслөөр чадавхжиж буй бригадуудын төлөөллүүд идэвхтэй оролцлоо. Уулзалтаар салбарын ААНБ, бизнес эрхлэгчдэд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны бодлого, өөрчлөлт, шинэчлэлт хийж байгаа хууль болоод шинээр боловсруулж байгаа хуулийн төслүүд, норм дүрэм, журмуудад ямар өөрчлөлт оруулж байгаа талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү танилцуулахаас гадна, Бид салбартаа ямар хувь нэмэр оруулж чадах вэ?” багаар

ажиллах & байр сууриа солилцох сэдвийн хүрээнд оролцогчид идэвхтэй багаар ажиллуулж энэ удаагийн чөлөөт уулзалт амжилттай болж өнгөрлөө.

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ ТББ-ЫГ ЦАГААН САРЫН БАЯРЫН ЗОЛГОЛТЫН АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО



МБҮА ТББ нь Гишүүн байгууллагуудын хүрээнд Монголын цагаан сарын баярын үйл ажиллагаа, золголтын арга хэмжээг зохион байгууллаа.

МОНГОЛЫН НОГООН БАРИЛГЫН ХҮРЭЭЛЭНГИЙН БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛД ОРОЛЦЛОО



Монголын Ногоон Барилгын Хүрээлэн нь 2014 үүсгэн байгуулагдсан бөгөөд 2022.08-р сард Удирдах Зөвлөл, бүтэц, Ажлын алба шинэчлэгдэн, зорилго үзэл баримтлалаа Дэлхийн Ногоон Барилгын Зөвлөлтэй нийцүүлэн Монгол Улсад ногоон барилгын үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх, нэвтрүүлэх зорилгоор үйл ажиллаж байна.

Хүрээлэн нь одоогоор 70 гаруй гишүүдтэй ба барилгын салбарын чадавхыг бэхжүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, ногоон барилгын технологи, BestGER ногоон барилгын гэрчилгээжүүлэлт, түүний зэрэглэл, дэвшилтэт норм түүнчлэн эрчим хүчний үр ашгийн стандартыг сурталчлах, нэвтрүүлэх, талуудын хамтын ажиллагааг сайжруулан манлайлан ажиллаж байгаа бөгөөд **Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ** нь 2023 оноос эхлэн тус хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүн болоод байгаа билээ. Энэ удаагийн Бүх гишүүдийн хурлаар Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлан, зохион байгуулалт болон BestGER ногоон барилгын үнэлгээний системийг танилцууллаа. Энэхүү ногоон барилгын үнэлгээний системийг олон нийтэд танилцуулж, ногоон зээл авах, ногоон санхүүжилт авах ашиглах ба зураг төсөлд, ашиглалтад орсон барилгад ногоон барилгын гэрчилгээ олгох боломжтой юм байна.

МОНГОЛЫН НОГООН БАРИЛГЫН ХҮРЭЭЛЭН ДЭЛХИЙН НОГООН БАРИЛГЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН БОЛЛОО

Монголын Ногоон Барилгын Хүрээлэн Дэлхийн Ногоон Барилгын зөвлөлийн албан ёсны Гишүүн болсон арга хэмжээнд Дэлхийн Ногоон Барилгын зөвлөлийн (World Green Building Council) Европ, Төв Азийн бүсийг хариуцсан Дэд ерөнхийлөгч Ричард Тейхманн, тус хүрээлэнгийн Удирдах зөвлөлийн гишүүд болоод Гишүүн байгууллагуудын төлөөлөл оролцож Дэлхийн Ногоон Барилгын чиг хандлага, хэтийн төлөв, үйл ажиллагаа, зорилго зорилттой танилцлаа. Монголын Ногоон Барилгын Хүрээлэн ТББ нь хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, барилга байгууламжийн ашиглалтын зардлыг бууруулах, ногоон хөрөнгө оруулалтыг татах, иргэдэд ногоон зээлийн



ажиллаж байгаа юм. МБҮА нь МНБХ-ийн гишүүнийн хувьд барилгын салбарт ногоон барилгын бодлогыг хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байгаа бөгөөд агаарын бохирдлыг бууруулах Дулаан шийдэл төслийг 7 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. МНБХ-ийн зүгээс BestGER үндэсний ногоон барилгын үнэлгээний аргачлалыг хөгжүүлсэн ба барилга байгууламжийг Ногоон барилга гэж тодорхойлж, гэрчилгээжүүлэх эрхзүйн орчин, хүний нөөц, талуудын оролцооны талаар идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа билээ. Монголын Ногоон Барилгын Хүрээлэн Дэлхийн Ногоон Барилгын зөвлөлийн албан ёсны Гишүүн болсоноор BestGER ногоон барилгын үнэлгээний системийн Олон улсад хүлээн зөвшөөрөхөд чухал алхам болж, Ази болон Европийн бүсийн орнуудаас мэдлэг туршлага суралцах, өөрсдийн хийж байгаа ажлын үр дүнг Олон улсад таниулах чухал ач холбогдолтой юм.

БАРИЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРХЭН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ? СУРГАЛТЫГ ГИШҮҮДДЭЭ ХИЙЛЭЭ

МБҮА ТББ нь Олон улсын болон дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран гишүүн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах **СУРГАЛТ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ** зохион байгуулах зорилгын хүрээнд **PMI Mongolia Chapter** буюу Төслийн Удирдлагын Институттэй хамтран "PMI - Төслийн удирдлагын үндэс" сэдвийн хүрээнд **БАРИЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРХЭН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ ВЭ? Онол, практикийг хослуулсан сургалтын** сургагч багш, хөтөлбөр боловсруулах зэрэг зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Сургалт нь **Төслийн удирдлагын олон улсын стандартад суурилсан** бөгөөд оролцогчдыг мэргэжлийн түвшинд чадваржуулахад чиглэж байна.

Сургалтын гол агуулгууд:

- ✓ **Төслийн удирдлагын үндэс:** Төсөл, хөтөлбөр, портфолио, уламжлалт ба Agile аргачлалын ялгаа
- ✓ **Төлөвлөлт ба хэрэгжилт:** Шаардлага тодорхойлох, хугацаа, төсөв, эрсдэлийг төлөвлөх, гэрээ, худалдан авалт



- ✓ **Гүйцэтгэл ба хяналт:** Төслийн хэрэгжилтийн хяналт, гүйцэтгэлийн хэмжилт

Хаалтын үе шат: Сургамж дүгнэх, тайлагнах, мэдлэгийн сан бүрдүүлэх зэрэг болно.

МБҮА ТББ-ын ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД ТАТВАР, САНХҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ нь салбарын хууль эрх зүйн орчинд шинэчлэл хийх, олон улсын барилгын гэрээний зарчимд нийцүүлэн нэвтрүүлэх, барилгын салбарт сайн засаглалыг бий болгох, Гишүүн компаниудын компаниудын засаглал, өрсөлдөх чадварыг сайжруулах, мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, шинэ дэвшилтэт технологи, ноу-хауг нэвтрүүлэн нутагшуулах тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын чадавхыг сайжруулан хөгжүүлэх чиглэлд Гишүүн байгууллагуудаа байнга дэмжин, хамтран ажилладаг бөгөөд 2025.06.12-ны өдөр Татварын Хөгжил Дэвшил Холбоо ТББ-ын Тэргүүн Б.Ганболд тэргүүтэй сургагч багш нар МБҮА ТББ-ын Гишүүн компаниудын удирдах ажилтнуудад сургалт, мэдээллийг өглөө.

Сургалтын үеэр барилгын компаниудад хийгдсэн татварын хяналт шалтгалт хийгдэхэд гарсан зөрчлүүд, тайлан мэдээгээ хэрхэн хийх, юун дээр анхаарах, зөрчилтэй гарсан бол Татварын хэрэг маргаанд Татварын алба, Маргаан таслах зөвлөл, Шүүхийн байгууллагад төлөөлөх гэх мэтэд зөвлөгөө мэдээллээр хэрхэн хангагдах зэргээр хамтран ажиллах боломж бололцоо байгаа талаар мэдээллийг хүргэлээ.

“БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ +AI” СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь 2025.06.20-нд болох “БҮХ ГИШҮҮДИЙН ЧУУЛГАН VI”-ыг угтаж “БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ +AI” сургалтыг Гишүүн байгууллагууд болоод салбарынхандаа зориулан 2025.06.17-ны өдөр зохион байгууллаа.

Сүүлийн жилүүдэд барилгын салбарт хиймэл оюун ухааныг ашиглах нь эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд ингэснээр зардал бууруулах, хугацаа хэмнэх, чанарыг сайжруулах зэрэг олон давуу талыг үзүүлээд байна. Барилгын салбарынхан дунд зураг төслийн салбарынхан AI-г өргөн хүрээнд хэрэглэх болсон бөгөөд BIM (Building Information Modeling) буюу барилгын мэдээллийн загварчлалд хиймэл оюун ухаан ашиглан барилгын зураг төслийн алдаг эрт илрүүлж, шийдэл санал болгодог болсон



нь тухайн барилга алдаатай баригдахаас урьдчилан сэргийлж төсөв болоод зардлыг маш ихээр хэмнэж байна. Энэ удаагийн сургалтаар Дата гэр ХХК-ийн захирал Г.Гүен нь БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ +AI сэдвийн дор AI-ийн өнөөгийн нөхцөл байдал, дата баазыг хэрхэн бий болгох, хэрэглэх, аюулгүй байдлыг хэрхэн

хамгаалах талаарх ойлголтыг хүргэсэн болгох МБҮА ТББ-ын захирал Г.Батсүх барилгын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд барилгын салбарын дата баазыг хэрхэн ашиглах, боломж бололцоо юу байгаа талаар оролцогчдод танилцууллаа.

Мөн одоогийн байдлаар барилгын салбарт хиймэл оюун ухаан (AI) нэвтрүүлэхэд Монгол Улсын хууль эрх зүйн орчныг шинэчлэх шаардлага үүсэж байгаа ба одоогийн барилгын норм, дүрэм, тусгай зөвшөөрөл, хяналт, мэдээллийн хамгаалалт зэрэг олон эрх зүйн заалтууд AI болон дижитал технологийн хэрэглээг нарийвчлан зохицуулж чадахгүй байгааг онцолсон юм.

БАРИЛГЫН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ ХАБЭА СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Улсын хэмжээнд барилгын салбарт сүүлийн 5 жилд 180 үйлдвэрлэлийн осол бүртгэгджээ. Ослын шалтгааныг авч үзвэл, нийт ослын 39,4 хувь нь өндрөөс унах, бүдрэх, хальтрах,16,6 хувь нь эд зүйлд хавчуулагдах, 16,1 хувь нь унаж байгаа эд зүйлд цохиулах гэсэн хүчин зүйлээс хамаарч байна. Барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ихэнхи аж ахуйн нэгж, байгууллага нь ХАБЭА-н хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлдэггүй, ХАБЭА-н ажилтан, алба, хэлтсийг зохих орон тоогоор ажиллуулдаггүй, орон тооны тогтвортой ажилчид байхгүй, олон чиглэлээр түр зуурын туслан гүйцэтгэгч авч ажиллуулдаг, ХАБЭА-н урьдчилан арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө зардал гаргадаггүй, ХАБЭА-н менежментийн тогтолцоо нэвтрүүлдэггүй зэрэг нь энэ салбарт үйлдвэрлэлийн осол гарах, улмаар ажилтны амь нас, эрүүл мэнд хохирох үндсэн шалтгаан болж байгаа ба үүнээс үүдэлтэй барилга, уул уурхай, зам тээвэр гэвэл салбар салбаруудын онцлогт тохируулсан ХАБАЭ-ын сургалт явуулдаг байх нь чухал болоод байна. Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь ХББОСЯ, БХТ ТӨҮГ, МБИХолбоо-той хамтран удирдах ажилтнуудад ХАБЭА-н хууль тогтоомж, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт болон байгууллагын ХАБЭА -н чадварын мэдлэг олгож чадавхжуулах, болзошгүй осол эрсдэлээс хамгаалах зорилгоор 2025.08.14, 10.23-ны өдрүүдэд “БАРИЛГЫН ХАБЭА УДИРДАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ”-ыг зохион байгууллаа. Сургалтаар барилгын салбарын эрсдэлийн үнэлгээ, техник технологи, аюулгүй байдал нь ямар хууль, эрхзүйд нийцүүлсэн байх ёстой юм, салбарын онцлогийг тусган салбарт ХАБ-ыг хэрхэн мөрдөж ажиллах, ямар аюул эрсдэл учрах вэ, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ, ямар хууль эрхзүйг баримтлан ажиллах вэ гэдгийг сургалтаар өглөө. Сургалтын үеэр, сургалтад хамрагсдад дунд олон улсын жишиг, стратеги төлөвлөлт, анхаарах асуудал зэрэг сонирхолтой сэдвээр мэдээлэл, нээлттэй сэтгэгдлийг сонсон, хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлсэн бөгөөд гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн холбогдох байгууллагуудад зохион байгуулагчийн зүгээс нэгтгэн хүргэхээр болсон юм.



“НЭГ БҮС НЭГ ЗАМ“ УУЛЗАЛТАД МБҮА ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР ИЛТГЭЛ ТАВИЛАА



БНХАУ-ын Шандон мужийн Линьи хотын даргын урилгаар Хүннү хотын захирагч М.Батбаяр, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Хүннү хотын Хөгжлийн корпорацийн захирал Г.Гүнболд нар зочилж албан ёсны айлчлал хийлээ. Линьи хот нь 12 сая хүн амтай, сүүлийн 20 жилд төлөвлөлтөө шинэчлэн орчин үеийн шинэ хотыг байгуулж, байршлын давуу талаа ашиглан цахим худалдаа, ложистикийн төвүүдийг байгуулан, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Монгол Улсын 1200 гаруй компани Линьи хотоос төрөл бүрийн бараа материал худалдан авч импортолж байна. Линьи хотын дарга Монгол Улсын зочид төлөөлөгчдийг хүлээн авч уулзаж хамтран ажиллах шинэ эхлэл тавигдаж байгааг онцлон тус хотын Хот төлөвлөлтийн үзэсгэлэн, Радио телевизийн цамхаг, барилга бүтээн байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд, Линьи хотын худалдааны хөндий, тээвэр ложистикийн төвтэй танилцууллаа. Хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх “Нэг бүс нэг зам“ уулзалт арга хэмжээнд 200 гаруй төлөөлөгчид оролцож, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх Монгол улсын барилга бүтээн байгуулалтын салбарын талаар илтгэл танилцуулж, оролцогчдын сонирхсон асуултад хариуллаа. Цаашид Монгол Улсад барилгын материал нийлүүлэх, хот төлөвлөлт, барилгын төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар боллоо.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ СВИЧ ЭШИА ТӨСЛИЙН БАГИЙНХАНТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



Европын Холбооны Свич Эшиа төслийн Азийн бүс нутгийг хамарсан бодлогод дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн хэсгийн (Policy Support Component PSC) шинжээч ноён Флориан Беранек, П.Мөнгөнчимэг нартай МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болоод гишүүн байгууллагын төлөөлөл болох Ай Ди Си Ай ХХК – захирал Э.Ванчиндорж, Эм Пи Ай Консалтантс ХХК – н.Долоодой нарын хамт уулзаж санал солилцлоо. Уулзалтаар барилгын салбарын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, тогтвортой хөгжил, ногоон барилга, барилгын материалын хог хаягдлын дахин боловсруулалт аргачлалын талаар ярилцлаа. Мөн цаашид энэ чиглэлээр хэрхэн хамтран ажиллах тал дээр ойлголцолд хүрч ажил хэрэг болгох талаар санал нэгдлээ.

“TURKEY BULD-2025“ ҮЗЭСГЭЛЭН ЭКСПОД МБҮА ТББ-ЫН 20 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫГ ХАМРУУЛЖ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛЭВ

МБҮА ТББ нь жил бүр БНТУ-д болдог “TURKEY BULD-2025“ үзэсгэлэн экспод Гишүүн байгууллагуудаас нийт 20 орчим



хүнийг оролцуулж Турк улсын барилгын салбарын шинэ техник, технологитой танилцах хамтын ажиллагааны боломж бололцоог эрэлхийлэх хүрээнд арга хэмжээнд оролцууллаа. Тус үзэсгэлэн арга хэмжээний үеэр Инэл ХХК, Скэч ХХК, Заг инженеринг ХХК, Барилгачин групп ХХК-ууд харилцан хамтын ажиллагаа эхлүүлэх, хамтран ажиллах, шинэ санаа шийдлийг зураг төсөвтөө тусгах зэргээр үр дүнтэй арга хэмжээ болсныг дурдсан юм.

БАРИЛГЫН САЛБАРЫН “НОГООН БАРИЛГЫН МАНЛАЙЛАГЧ” НАР ТОДОРЛОО

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, “Алсын хараа 2050” зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд ногоон хөгжлийг эх орондоо нутагшуулах, дагаад барилга, хот байгуулалтын салбарт уг чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн нөхцөл бололцоог нэмэгдүүлэх, холбогдох барилгын норм ба дүрмүүдийг шинэчлэх зайлшгүй шаардлага бий болсны дагуу “Ногоон барилгын хүрээлэн” ТББ (Green building council NGO) шинэчлэн байгуулж Төлөөлөн удирдах зөвлөлийг баталсан бөгөөд тус зөвлөлд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ багтдаг билээ. Монголын ногоон барилгын салбарын манлайлагчдыг тодруулж, тэдний бүтээлч санаачилга, хичээл зүтгэлийг үнэлэх зорилгоор "Ногоон Барилгын Манлайлагч" шалгаруулах ёслолыг 2024.12.05-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд УИХ, Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, УИХ-ын гишүүн А.Ундраа, Барилгын Хөгжлийн Төв ТӨААҮГ-ын захирал Т.Пүрэвхатан, НБХ-ийн Гүйцэтгэх захирал Ц.Батгэрэл, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар оролцлоо. “Ногоон барилгын манлайлагч”

- “Хүрээлэн буй орчин” бүлэг-т Н.Дорж
- “Эрчим хүч, дулаан” бүлэг -т Пассив хаус хүрээлэн Н.Ганбаа
- “Материал болон нөөц” бүлэг -т Монгол Базальт ХХК -ийн Ерөнхий захирал Л.Ариунболд
- “Усны хэмнэлт” бүлэг-т Ультрасоник ХХК



захирал Б.Чимэгцэцэг
- “Дотоод орчны чанар” бүлэг -т МАК Евро Венти үйлдвэр
-“Тэсвэржилт” бүлэгт - Japan Internatinal Cooperation agency - Жайка Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Мияги Кэнсүеэ, В.Ойдов
- “Эрчим хүч ба усны хэмнэлт” бүлэгт Ж.Чинзориг нар тус тус шалгарлаа.

МБҮА ТББ НЬ ОРОН НУТАГТ САЛБАР ЗӨВЛӨЛӨӨ БАЙГУУЛЖ ЭХЭЛЛЭЭ



Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь өнгөрсөн 15 жилийн хугацаанд хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу өөрийн гишүүд, салбарын ТББ-ууд болон Төрийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын эдийн засагт тохиолдсон удаа дараагийн хямрал, хүндрэлүүдийг даван туулахад салбарын дуу хоолой болон манлайлан ажиллаж Төр засгаар тодорхой шийдвэрүүд гаргуулж, үр дүнд нь зөвхөн гишүүдэд төдийгүй энэ салбарт ажиллаж буй нийт бизнес эрхлэгчдэд эерэг нөлөөллүүд бий болгож иржээ.

Монголын барилгын салбарын хөгжил, эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь үндэсний барилгын компаниудын нэгдэл болохын хувьд нийслэл төдийгүй орон нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлж салбар зөвлөл байгуулах ажлыг эхлүүллээ. Тус ажлын хүрээнд 21 аймагт салбар зөвлөлийг байгуулж, орон нутгийн барилгын компаниуд, мэргэжилтнүүдийг нэгтгэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Салбар зөвлөлүүд нь тухайн аймаг, орон нутгийн барилгын компаниудын эрх ашгийг хамгаалах, барилгын салбарын хөгжлийг дэмжих, шинэ технологи, стандартыг нэвтрүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах юм.



ХОВД АЙМГИЙН БАРИЛГЫН КОМПАНИЙН ТӨЛӨӨЛЛҮҮДТЭЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



МБҮА ТББ нь 21 аймагт салбар зөвлөлийг байгуулж, орон нутгийн барилгын компаниуд, мэргэжилтнүүдийг нэгтгэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго тавин ажиллаж байгаа ба 2025.03.14-ны өдөр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх, Гишүүнчлэл хариуцсан менежерүүдийн хамт Ховд аймгийн барилгын салбарын төлөөллүүдтэй цаашид хэрхэн хамтрах ажиллах талаар санал солилцлоо.

ХОВД, БАЯН-ӨЛГИЙ, ДАРХАН-УУЛ АЙМГУУДАД САЛБАР ЗӨВЛӨЛТЭЙ БОЛЛОО

Монголын барилгын салбарын хөгжил, эрх зүйн орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь үндэсний барилгын компаниудын нэгдэл болохын хувьд нийслэл төдийгүй орон нутагт үйл ажиллагаагаа өргөжүүлж салбар зөвлөл байгуулах ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд МБҮА ТББ-ын Салбарын бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн дарга М.Энхбаатар, Ажлын албаны төлөөлөл орон нутгуудад ажиллалаа.

2025.05.02-ны өдөр Ховд аймагт 18 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож үүсгэн байгуулах хурлаа хийж үүсгэн байгуулагчаар 7 хүнийг сонгож Салбарын Тэргүүнээр Б. Туулайтулга сонгогдлоо.

2025.05.03-ны өдөр Баян-Өлгий аймагт 14 барилгын компаниудын төлөөлөлтэй хуралдаж тус аймаг дахь Салбар зөвлөлийн Тэргүүнээр Г. Жанисбекийг сонголоо.

2025.05.04-ны өдөр Дархан-Уул аймагт ажиллаж тус аймагт салбар зөвлөл байгуулах хуралд 13 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож тэргүүнээр С.Дэлгэрбаярыг 100 хувийн саналаар тус тус сонголоо. Өнгөрсөн хугацаанд МБҮА ТББ нь хөгжлийн стратеги төлөвлөгөөний дагуу өөрийн гишүүд, салбарын ТББ-ууд болон Төрийн холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын эдийн засагт тохиолдсон удаа дараагийн хямрал, хүндрэлүүдийг даван туулахад салбарын дуу хоолой болон манлайлан ажиллаж Төр засгаар тодорхой шийдвэрүүд гаргуулж, үр дүнд нь зөвхөн гишүүдэд төдийгүй энэ салбарт ажиллаж буй нийт бизнес эрхлэгчдэд эерэг нөлөөллүүд бий болгож ирсэн билээ. Мөн барилгын бизнесийн орчныг сайжруулах, зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулах ажлыг манлайлан ажилласны үр дүнд энэ ажлыг өнөөдрийн байдлаар уг үйл ажиллагаа бүрэн цахимжиж, тусгай







зөвшөөрлийн журмыг хялбаршуулан ажлын 5-7 хоногт зөвшөөрлөө авдаг болоод байна.

БОДЬ ПРОПЕРТИЙЗ" ХХК-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2 АЙЛ ӨРХИЙН БАЙШИНГ БҮТЭН ДУЛААЛЖ, ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ



Бодь Пропертийз ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд МБҮА ТББ-ын хамтран хэрэгжүүлж буй "Дулаан шийдэл II" төсөлд 2 айл өрхийн байшинг бүтэн дулаалах санхүүжилт олгосон. Ингэхдээ Улаанбаатар хотын байшинтай өрхүүдийн дунд нээлттэй шалгаруулалт зарлаж, 12 шалгуур үзүүлэлтээс хамгийн өндөр үнэлгээ авсан СХД-ийн 22-р хорооны иргэн Г.Хүрэлбаатар болон СХД-ийн 7-р хорооны иргэн Б.Үрлээгийн байшинг тус тус бүтэн дулаалахаар сонгосон юм. Тус хоёр байшингийн хана, дээвэр, суурь дулаалах, хаалга, цонх солих ажлыг "Дулаан шийдэл II" төсөлд хамрагдаж, дулаалгын технологид суралцсан Ц.Пүрэв, Ц.Цогт-Эрдэнэ ахлагчтай барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид 2025.02.04-18-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Байшинг технологийн дагуу зөв, бүрэн дулаалснаар тухайн айл өрхөд 50 ба түүнээс дээш хувийн эрчим хүчний хэмнэлт үүсэж, тэр хэрээр түлш зарцуулалт багасан, өрхийн эдийн засагт эергээр нөлөөлөх, дотор агаарын чанар сайжрах зэрэг боломж бүрдлээ. Ийнхүү 2025.02.18-нд дулаалгын ажлын үр дүнг айл өрхүүдэд Бодь Пропертийз ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Тэгшбаяр, МБҮА ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Батсүх нар хүлээлгэн өгөв. Тус хоёр байшинг дулаалахын өмнө “Дулаан шийдэл II” төслөөс дулаан алдагдлыг илрүүлэх зорилгоор камертай хэмжилт хийж, дулааны тав тух болон дотор агаарын чанарыг хэмжихээр өвлийн хэмжилтийн багаж суурилуулаад байна. Мөн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулна. Ийнхүү тодорхой хугацааны дараа үр дүнг хэмжих, мэдээлэх, эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ гаргах зэрэг ажлыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.

"ДУЛААН ШИЙДЭЛ-II" ТӨСЛИЙН ШИЛДЭГ ГҮЙЦЭТГЭГЧДИЙГ УРАМШУУЛЛАА





“Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажилладаг бизнес эрхлэгчдээс 2024.06-2024.11-р сарыг дуусталх ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр тэргүүлсэн шилдэг 5-н гүйцэтгэгч буюу Дулаалгын зөвлөх, Топ мастер ХХК-ийн захирал, МБҮА ТББ-ын дэд гишүүн Ш.Баярсайхан, Ц.Гаябазар, Т.Базар, Ж.Есүхэй, Ц.Цогт-Эрдэнэ нар шалгарлаа.

"ДУЛААН ШИЙДЭЛ I, II" ТӨСЛИЙГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЖЭРЭС ОУТББ-ЫН УДИРДЛАГУУДТАЙ УУЛЗЛАА



МБҮА ТББ нь агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах, барилгын салбарт дулаалгын зах зээл, эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулах, салбарын ажиллах хүчнийг чадавхжуулах зэрэг зорилгоор 2018 оноос хойш Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл I, II” төслийг бусад түншлэгчийн хамтаар хэрэгжүүлж байна. Төслийн үйл ажиллагаа, цаашдын тогтвортой байдлыг хангах, барилгын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагын талаар харилцан байр сууриа солилцох зорилгоор МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх өнөөдөр (2025.03.12) Жэрэс ОУТББ-ын Азийн бүс хариуцсан захирал Квентин Морро, тус байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгч Завьер Рат нарыг хүлээн авч уулзав. Уулзалтаар талууд олон жил хамтарч ажиллаж ирсэн туршлагадаа тулгуурлан, цаашид үргэлжлүүлэн үр дүнтэй хамтран ажиллахаа илэрхийллээ.

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ДУЛААЛСАН БАЙШИНТАЙ ТАНИЛЦАХ, ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



“Дулаан шийдэл II” төслийн хүрээнд бүтэн дулаалга хийсэн СХД-ийн 7-р хорооны иргэн У.Насанбатын байшинг танилцуулах замаар дулаалга, эрчим хүч хэмнэлтийн талаар төр, хувийн хэвшил, иргэдэд тайлбарлан таниулах, Дулаалга хийлгэснээр гарсан үр дүнгийн талаар айл өрхийн байр суурь, сэтгэгдлийг сонсох, дулаалгын технологийн талаар Төслийн инженер, гүйцэтгэгчидтэй ярилцан ач


холбогдлыг олон нийтэд таниулан сурталчиллаа.

МБҮА ТББ-ЫН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА БОЛОН ЕВРОПЫН ХОЛБООНЫ СВИЧ-ЭШИА ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТТЭЙ “ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ДУЛААЛГЫН ЗӨВЛӨХҮҮДИЙНХЭЭ ДУНД ӨГЛӨӨНИЙ АЖИЛ ХЭРЭГЧ БИЗНЕС УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

МБҮА ТББ-ын гишүүн байгууллагууд болон Европын холбооны СВИЧ-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн дулаалгын зөвлөхүүдийнхээ дунд "Өглөөний ажил хэрэгч бизнесийн уулзалт" зохион байгууллаа. Энэхүү уулзалтын зочид болох “Гурван бухат групп” ХХК-ийн ерөнхий захирал Т.Ганчимэг, “Добу технологи” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Тулгабаатар нар бизнес эрхлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалт босгохоос эхлээд гүйцэтгэлдээ анхаарах, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөртөө мэдээллийн технологийн оновчтой шийдлүүд нэвтрүүлэх нь зүйтэй талаар хэлж байв.“Аливаа асуудал тулгарлаа гэхэд түүнийг бэрхшээл гэж харалгүй, гарц хайдаг. Хэлсэндээ хүрдэг байх нь хамгийн чухал" гэдгийг Т.Ганчимэг онцолж байсан бол “Сүүлийн үеийн технологийн чиг хандлага нь эрүүл амьдралын хэв маягт чиглэж байгаа” талаар Д.Тулгабаатар оролцогчдод мэдээлэл өглөө. Мөн уулзалтаар “Бульдорс Мон ХХК”, “Ультрасоник” ХХК, “Динамик тауэр” ХХК өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ онцлог, давуу талыг танилцуулав.











"ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛӨӨС ЧАДАВХЖСАН БАРИЛГЫН САЛБАРЫН БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

"ДУЛААН ШИЙДЭЛ II" төслийн зүгээс 2024 оны намрын элсэлтийн чадавхжуулах багц хөтөлбөрт бүрэн хамрагдсан, цаашид дулаалгын зөвлөхөөр ажиллах сонирхолтой 8 барилгын салбарын бизнес эрхлэгчдэд дулаалгын ажил хийж гүйцэтгэх зөвлөмж, МБҮА ТББ-ын зүгээс хамтран ажиллахад анхаарах зүйлсийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.



"ДУЛААН ШИЙДЭЛ II"-ТӨСЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ЗӨВЛӨХ ХОРООНЫ ХУРАЛ БОЛЛОО



“Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны төсөл, хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх боломж” сэдвээр болсон тус хуралд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх: "Манай байгууллага нь Дулаан шийдэл төслийг 2018 оноос хойш хамтран хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд 200 гаруй барилгын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчийг дулаалгын технологи, барилгын дулаан хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, хог хаягдлын менежмент, бизнесийн ёс зүй зэрэг чиглэлээр чадавхжуулж, дулаалгын зах зээлд холбон зуучилж, нэмэлт орлого олох боломжоор хангалаа. Цаашид барилгын дулаалгын чиглэлээр мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр анхаарч ажиллах болно. Мөн амины орон сууцыг анхнаас нь зураг төсөлтэй барьдаг байх талаар холбогдох хууль, дүрэм журамд өөрчлөлт оруулахад анхаарч ажиллая гэж төлөвлөж байна. Цаашид бид илүү олон дулаалгын зөвлөхийг бэлтгэх, олон айл өрхийг дулаан, тав тухтай байх нөхцөлийг хангахын төлөө дотоод нөөц бололцоогоо ашиглахын зэрэгцээ гадаадын хөрөнгө оруулалт татах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг зорьж байна" гэдгээ илэрхийлсэн юм.

“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСӨЛТЭЙ ШИНЭЭР ХАМТАРЧ АЖИЛЛАХ 16 БАРИЛГЫН САЛБАРЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

"Дулаан шийдэл II" төслийн хүрээнд МБҮА ТББ-тай Хамтран ажиллах Санамж бичиг байгуулах, төслийн дулаалгын зөвлөхөөр ажиллах талаар зөвлөмж өгөх, айл өрхийн байшингийн дулаан алдагдлыг илрүүлэх, дулаалгын үнэлгээ гаргахад шаардлагатай багц гардуулах, төслийн ажилд зуучлах, нэмэлт орлого олох нөхцөлийг бүрдүүлэх гэх мэт зорилгын хүрээнд хийгдлээ.












“ДУЛААН ШИЙДЭЛ II” ТӨСЛИЙН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ХУРАЛД ТУС БҮР ОРОЛЦОЖ ҮР ДҮНГ ХЭЛЭЛЦЭВ







"Дулаан шийдэл II төсөл"-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд 14 хоног тутамд онлайн уулзалт зохион байгуулагддаг бөгөөд уулзалтаар тухайн

хоёр долоо хоногтоо хийгдсэн ажлын тайлан мэдээ болон ирэх хоёр долоо хоногт хийгдэхээр төлөвлөгдсөн ажлын мэдээлэл солилцдог билээ. Үүний хүрээнд энэ удаагийн уулзалтыг “ЖЭРЭС” ОУТББ биет хэлбэрээр зохион байгуулсан. Мөн уулзалтаар төслийн нөлөөллийн үнэлгээний судалгааны тайланг танилцууллаа. Судалгаанд 585 айл өрх хамрагдсан ба 47% дулаалгагүй, 27% хагас дулаалгатай, 26% нь бүтэн дулаалгатай байв. Судалгааны үр дүнгээс харахад Дээврийн дулаалга нь бие болон сэтгэл зүйн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлдөг бөгөөд байшингийн тав тухтай байдал, үнийн талаарх үзэлд мөн эерэг нөлөө үзүүлдэг байна. Тус хамтран ажилладаг байгууллагын хүрээнд 7 хуралд сууж саналаа өгч ажиллалаа.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАРТАЙ МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



НЗДТГ-аас зохион байгуулсан Барилгын ажил эхлэх зөвшөөрөл авах, архитектур төлөвлөлтийн даалгавар, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа, барилгын хяналтын асуудлаар зохион байгуулсан арга хэмжээнд оролцож мэдээлэл авлаа. Мөн 2025 оны 4 дүгээр сарын 10-нд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х. Нямбаатартай уулзалт хийж Улаанбаатар хотын 2040 оны ерөнхий төлөвлөгөө, барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилгыг улсын комисст хүлээн авах дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ярилцан, холбогдох саналаа албан бичгээр өгсөн болно.

ИРГЭДИЙН ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АСУУДЛЫГ СУДАЛЖ, САНАЛ, ДҮГНЭЛТ БОЛОВСРУУЛАХАД ГИШҮҮДЭЭС САНАЛ АВАХ УУЛЗАЛТ БОЛЛОО

Зорилтын хүрээнд орон сууцны санхүүжилтийн тусгайлсан чиг үүрэгтэй банк байгуулах асуудлыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын Захирамжаар байгуулсан. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан нар ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүргийн дагуу загварын төсөлд мэргэжлийн ТББ, компаниудаас санал авах уулзалтыг 2024.08.20-ны өдөр зохион байгуулав. Уг уулзалтыг ХБББОСЯ-ны Газрын инженерийн дэд бүтцийн хэлтсийн дарга Э.Батболд удирдан чиглүүлж, МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болон гишүүн компаниудын төлөөлөл, Ажлын албаны ажилтнууд оролцож санал бодлоо хуваалцлаа. Уулзалтаар ногоон барилгын санхүүжилт, ТОСК, НОСК-ийн эрх мэдлийн хуваарилалт, дулааны тархмал



эх үүсвэрийн асуудал, ажиллах хүчний зардлын асуудал, барилгын материалын ханган нийлүүлэлт, гэр хороололд амины орон сууц барих, бага төвөгшилтэй барилга барих журмын талаарх гэх зэрэг өргөн хүрээний асуудлаар саналаа хэлэв. МБҮА ТББ-ын гишүүн компаниудаас нэмэлтээр санал хүлээн авч нэгтгэн, яаманд хүргүүлэхээр тогтлоо.

БАРИЛГЫН КОМПАНИУДАД ГАЛЫН МАГАДЛАЛ ХИЙХ, ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫГ ХЯЛБАРШУУЛАХААР МБҮА ТББ ОБЕГ-ЫН УДИРДЛАГУУДТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



Барилга бүтээн байгуулалтын салбарынханд төслийн ажлаа хийж гүйцэтгэх, ашиглалтад өгөх, техникийн нөхцөл авах, галын зөвшөөрөл авч эх загвар зураг (эскиз), иж бүрэн ажлын зураг батлуулах зэрэг үйл ажиллагаанд маш олон асуудлууд гардаг бөгөөд уг ажлын хүрээнд МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх ОБЕГ-ын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга хурандаа Д.Баян-Эрдэнэ, тасгийн дарга дэд хурандаа Б.Мягмаржав нартай цаг үеийн болон тулгамдсан асуудлын талаар 2024.11.13-ны өдөр уулзалт хийлээ. Уулзалтаар барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийх, улсын комисст ажиллах, барилгын үйл ажиллагаанд явцын хяналт хийхэд гарч байгаа тулгамдсан асуудлыг ярилцаж, уг асуудлыг цаашид хэрхэн хялбаршуулах гарц шийдлийн талаар болон бусад цаг үеийн асуудлаар санал солилцож улмаар барилгын салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудтай 2024.12.03-ны өдөр ажил хэргийн уулзалт хийж хамтран ажиллахаар тогтлоо.

ТЕНДЕРТ ОРОЛЦОЖ БУЙ БАРИЛГЫН КОМПАНИУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт томоохон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу уг бүтээн байгуулалтад оролцох, хамтрах барилгын компаниудыг шалгаруулах хууль эрх зүйд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй нөхцөл үүсээд байгаа талаар Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд гишүүний Ажлын албаныхан барилгын салбарын төрийн бус байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийлээ.Уулзалтаар өнөөдрийн мөрдөгдөж байгаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд нийтлэг зарчмын дагуу явагддаг, хамгийн бага үнийн санал өгсөн компанийг шалгаруулах гэх мэтээр бүтээн байгуулалтад оролцож буй компаниудын шалгуур үзүүлэлтийн нөхцөл байдал тодорхой бус байдаг нь барилгын чанар болоод хугацаа алдагдах, гэрээний маргаан үүсэх гээд олон маргаан дагуулах болсон талаар санал солилцож, хуулийн хаана нь ямар зүйл заалтыг өөрчлөх, саналаа тусгах зэрэг дээр барилга бүтээн байгуулалтыг босгож буй компаниудын төлөөллүүдийг оролцуулж, санал бодлыг тусгаж ажиллах тал дээр ойлголцолд хүрлээ. МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал



Г.Батсүх уулзалтад оролцож тендер шалгаруулалт шударга бус явагддаг, санхүүжилт авах гэж хүнд сурталтай тулгардаг, төсвийн үнэлгээг зах зээлийн үнээр тооцох, 1 барилгын санхүүжилтийг олон жил дамнуулан санхүүжүүлэхийг болих, бага үнээр биш чанарын шалгуураар үнэлэх, тендерт олон тусгай зөвшөөрөл шаардахгүй төслийн менежментийг хэрэгжүүлсэн санхүүгийн чадавхтай компанийг сонгох, цаашид

тендерийн тогтолцоог өөрчилж олон улсын жишигт хүргэн хууль дүрэмдээ өөрчлөлт оруулж шинэчлэхийг санал болголоо. Мөн гишүүн байгууллагуудынхаа саналыг авч тендерийн хууль дүрэмд бичгээр санал өгөхөөр боллоо.

АЖИЛ ОЛГОГЧДОД ХҮНДРЭЛ УЧРУУЛЖ БУЙ ХУУЛИЙГ ЗАСАЖ САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХАА ГБХНХ-ЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ИЛЭРХИЙЛЛЭЭ



Үндэсний баялгийн сан-Орон сууцжуулалтын Үндэсний хорооны анхны хурал удахгүй зохион байгуулахтай холбоотой Гэр бүл, Хөдөлмөр Нийгмийн Хамгаллын Сайд Л.Энх-Амгалантай МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар 2024.11.05-ны өдөр уулзаж орлогод нийцсэн орон сууцны бодлого, бизнес эрхлэгчдэд тулгамдаж байгаа асуудлын талаар санал солилцлоо. Үндэсний баялгийн сан-Орон сууцжуулалтын Үндэсний хорооны гишүүнээр сонгогдсон МБҮА ТББ нь амины орон сууцыг ипотек хамруулах, бага дунд орлоготой иргэдийг орон сууцанд оруулахад ямар бодлого баримтлах талаар саналыг боловсруулахад оролцож ажиллаж байгаагаа дурдлаа.Мөн МБҮА ТББ-ын зүгээс “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 19.1.2-р заалтад “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлс”-ийг даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд оруулж тооцон нийгмийн даатгалын шимтгэл авахаар заасан нь аж ахуйн нэгж байгууллагуудад болон гэрээгээр ажил гүйцэтгэж буй иргэдэд маш их хүндрэл, дарамт болж байгааг Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгаллын Сайд Л.Энх-Амгаланд албан хүсэлт илгээсний дагуу уг хуулийн 19.1.2 заалтыг хүчингүй болгох, уул уурхайгаас бусад салбарын гадаадаас ажиллах хүчин авах квот, татварыг тэглэх, Хөдөлмөрийн хуульд байгаа заалтыг засаж сайжруулах талаар ажиллахаа ойрын хугацаанд шийдвэрлэнэ гэдгээ илэрхийллээ.

ХОТЫН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРТОЙ МБҮА ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАТСҮХ УУЛЗАЖ СТАНДАРТЫГ МӨРДҮҮЛЭХ ТАЛ ДЭЭР САНАЛ СОЛИЛЦОВ



МБҮА ТББ-ын захирал Г.Батсүх нь Нийслэлийн Ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэртэй уулзаж хот төлөвлөлт, зөвшөөрөл, стандартын талаар ярилцаж санал солилцлоо. Уг уулзалтаар Хот байгуулалт, стандартын газрын холбогдох дарга, албан тушаалтнуудын хамтаар

барилгын компаниудтай хамтарсан уулзалт зохион байгуулж салбарт тулгамдаад байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх, гарц гаргалгаа болоод стандартыг хэрхэн мөрдүүлэх талаарх асуудлуудыг ярилцаж шийдвэрлэх нь чухал гэдэг дээр санал нэгдлээ.

МНХ-НЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНЫГ 5 УДАА ХИЙЖ ОЙЛГОЛЦОЛД ХҮРЭВ



Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль нь 2025.01.01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурлаас 2024.09.12-ны өдөр “Ажлын хэсэг”-ийг Дэд ерөнхийлөгч, НБИК ХХК-ийн Гүйцэтгэх захирал Баяраа, Дэд ерөнхийлөгч, Номин констракшн девелопмент групп -ийн гүйцэтгэх захирал Б.Хүрэлхүү, УЗГ, Эс Ди Инженеринг Энд Констракшн ХХК-ийн захирал Б.Баасансүрэн нар оролцлоо.

МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД УИХ-ЫН ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО

МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч, Ультрасоник ХХК-ийн захирал Б.Чимэгцэцэг, НБИК ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Баяраа, Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар 2025.02.04 өдөр Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцтай барилгын салбарт тулгамдаж буй асуудал, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох үйл явц,



тавигдаж буй шаардлага, нөхцөл, түүнийг сайжруулахаар “Ажлын хэсэг” хэрхэн ажиллаж буй талаарх мэдээлэл болон ногоон барилга, ногоон технологийн талаар өнөөдөр баримталж буй бодлого, сайжруулалтын талаар санал солилцлоо. Уулзалтаар ирэх 2025.03-р сард барилгын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн төлөөллүүдтэй зангиагүй уулзалтыг хийж салбарын өмнө тулгамдаж буй асуудлаар санал солилцохоор боллоо.

“БИ БАРИЛГАЧИН ХҮН” ЧУУЛГА УУЛЗАЛТАД МБҮА ТББ ОРОЛЦЛОО

Монгол Улсын хөгжлийг түргэтгэх эдийн засгийн арга хэрэгсэл болох бүсүүдийг тодорхойлж, бүсүүдэд эдийн засаг, санхүүгийн дэмжлэг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, орон зайн төлөвлөлт бүхий зорилтуудыг Засгийн газраас зарлан ажиллаж байгаа бөгөөд Баян-Өлгий аймгийн ИТХ-ын дарга, түүний баг хамт олон болон хамтран ажилласан ААН компаниудын дэмжлэгтэйгээр "Би барилгачин хүн" чуулга уулзалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд МБҮА ТББ нь Түншлэгч байгууллагуудын хамт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох” үйл ажиллагааны өнөөгийн явц, тулгамдаад байгаа асуудал, тусгай зөвшөөрлийн журам, суурь нөхцөл байдалд оруулж буй өөрчлөлт шинэчлэлтийн талаарх мэдээллийг орон нутгийн барилгын



салбарынхан, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өглөө. Баян-Өлгий аймагт барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 43 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаа ба орон сууцны м2-ын үнэ нь 2,800-3,000,000 сая төгрөгийн үнэ ханштай байна. Мөн Өлгий хотын дулааны шугам сүлжээ, түүний насжилт, хүрэлцээ хангамжийн асуудал болоод төрийн тендер худалдан авах ажиллагааг шударга болгох инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх, залуучуудыг барилгын мэргэжил эзэмшүүлэх, барилгын компанийг чадавхжуулахад хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлж байлаа. Чуулга уулзалтад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын орон тооны зөвлөх М. Ибрай ахлуулсан салбарын мэргэжлийн ТББ-ууд болох Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Амины орон сууцны инновац хөгжлийн төв, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо зэрэг байгууллагууд оролцлоо.

СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН” НЭГДСЭН ХУРАЛДААНД БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО



“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхтэй холбоотойгоор "СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН” нэгдсэн хуралдааныг Төрийн ордонд зохион байгуулсан ба тус хуралдааны үеэр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх барилгын салбарын өмнө тулгамдаж буй асуудлын талаар асуудал дэвшүүллээ.

МБҮА ТББ-ЫН ГИШҮҮД ДУЛААНЫ СҮЛЖЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ ТАНИЛЦАЖ АЖЛАА ТӨЛӨВЛӨЛӨӨ

Нийслэл Улаанбаатар хотод томоохон бүтээн байгуулалт өрнөж буйтай холбогдуулан хотын ерөнхий төлөвлөгөөнд хаана, ямар дулааны эх үүсвэрүүдийг нэмэлтээр барих гэж байгаа болон БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН талаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх гишүүдийн хамт Улаанбаатар улааны сүлжээ ТӨХК-ийн дарга Ц.Амарсанаа

болон тус байгууллагын удирдлагуудын хамт уулзалт хийлээ.



БАРИЛГЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ, ҮНДЭСНИЙ ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГЫГ ХИЙЖ САНАЛАА ТУСГАВ



МБҮА ТББ НЬ ХББОСЯ-тай хамтран БАРИЛГЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ, ҮНДЭСНИЙ ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ-ийн ийн үзэл баримтлал, хуулийн төслийн танилцуулгыг 2025.03.10-ны өдөр зохион байгууллаа. ХББОСЯ-ны Барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батзориг, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн танилцуулга ХББОСЯ-ны Орон сууцны хэлтсийн дарга Э. Батболд нар нь барилгын салбарын хууль эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудал, эрх зүйн орчныг хэрхэн шинэчлэх тал дээр хуулийн төслүүдийг салбарын мэргэжлийн холбоо болох МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх болоод Удирдах зөвлөлийн гишүүд, гишүүдэд танилцуулж тэдний санал бодлыг тусгах тал дээр хамтран ажиллахаа илэрхийллээ. Нийслэлийн төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүсүүдийг хөгжүүлэх, иргэдийн орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ач холбогдолтой орон сууцны төслүүдийг үргэлжлүүлэх, бодлогоор хангахад хууль эрх зүйн шинэчлэл зайлшгүй шаардагдаж буй энэ хувьд эрх зүйн бичиг баримтуудад хувийн хэвшлийн саналыг тусгах, хуулийн цоорхой гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар талууд сэтгэгдлээ хуваалцлаа.

ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН БАГИЙНХАНТАЙ УУЛЗАЖ ТУРШЛАГАА СОЛИЛЦОВ

ЖАЙКА-Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага, СЯ, ЭЗХЯ, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын хамтран хэрэгжүүлэх Техникийн хамтын ажиллагааны “Улсын хөрөнгө оруулалтыг зохистой удирдах замаар болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх хүрээнд төслийн багийнхантай МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх гишүүдийн хамт уулзаж санал солилцлоо. Төслийн



хүрээнд Төр, хувийн хэвшлийн тухай хууль болон дагалдах дүрэм журмын дагуу хэрэгжих ТХХТ-ийн төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгон шалгаруулах, улмаар болзошгүй өр төлбөрийн талаас үүсэх эрсдэл талаас нь зөвлөмж өгөхөөс гадна, тус хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах холбогдох хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн гадаад болон дотоодын богино хугацааны сургалтыг зохион байгуулах юм байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГАД МБҮА ТББ САНАЛАА ТУСГАЛАА

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын Ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ нь 2025.03.26-ны өдөр барилгын салбарынхантай хуулийн төслийг шинэчлэх хэрэгцээ шаардлага, байр суурь, үзэл баримтлалын талаар танилцуулж улмаар барилгын салбарын өсөлт нь компаниудын ашиг, хөгжлөөр хэмжигдэх ёсгүй бөгөөд байр орон сууц худалдан авч буй иргэдийн эрхийг хамгаалсан, тогтвортой, хариуцлагатай бодлого хэрэгтэй байгаа талаар санал бодлоо солилцлоо. Барилгын тухай хуульд барилга байшин нь заавал зураг



төсөлтэй баригдана, барилгын материал нь заавал тохирлын гэрчилгээтэй байна гэж заасан байдаг ч нөгөө талдаа 9 метр өндөртэй, 600м2 байшинг зураг төсөлгүйгээр барьж болно гэсэн журам байдаг нь хууль хоорондын үл ойлголцол гарч байна. Мөн барилгын материалыг эрсдэл багатай ангилалд багтаасан нь хил гаалиар чанар, стандартын шаардлага хангахгүй бараа материал орж ирэх нөхцөлийг бүрдүүлж улмаар иргэд, хэрэглэгчийн эрх ашгийг хохироох асуудал үүсэж байгаа талаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх онцолж, хуулийн төсөлд Гишүүдээсээ авсан саналыг хүргэлээ.

БНСУ-ын ХАНИЛ КОМПАНИЙН УДИРДЛАГУУДТАЙ МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД УУЛЗАЖ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖТОЙГ ИЛЭРХИЙЛЛЭЭ




БНСУ-ын барилга, цементийн үйлдвэрлэл эрхэлдэг Hanil industrial ХХК-ийн Ерөнхий захирал Jung Uk-Jun, Ерөнхий менежер Lee Jonghoon болон бусад албаны хүмүүсийг МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх хүлээн авч уулзлаа. Hanil industrial ХХК-ийн төлөөлөгчид өөрсдийн үйл ажиллагаа, хэтийн төлөвлөгөө нь БНСУ-даа төдийгүй Азийн улс орнуудад хүрээгээ тэлж улмаар Монгол Улсад салбараа нээх, цар хүрээгээ тэлэх зорилгоор зах зээлийн төлөв байдал болоод хамтын ажиллагааны хүрээний талаар саналаа илэрхийлж цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал бодлоо солилцлоо.

ТАТВАРЫН БАГЦ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛТИЙН ТАЛААР БАРИЛГЫН САЛБАРЫНХАН САНАЛ СОЛИЛЦЛОО

УИХ-аас татварын багц хуулийн шинэчлэлийг удахгүй хэлэлцэн батлах гэж

буйтай холбогдуулан МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч Д.Энхтөр, Гүйцэтгэх захирал Г.Батсүх, МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ш.Үнэнбат,



МЗИХолбооны Ерөнхийлөгч Л.Шагдаррагчаа, БМҮХ-ны Гүйцэтгэх захирал Б.Цэрмаа, МБҮА ТББ-ын гишүүн Цаст Констракшн ХХК-ийн төлөөлөл нартай “Татварын хөгжил дэвшил холбоо” ТББ-ын тэргүүн Б.Ганболд тэргүүтэй төлөөллүүд 2025.05.06-ны өдөр татварын багц хуулийн шинэчлэл талаар санал бодлоо солилцлоо. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ууд орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл гээд татварууд төлөхөөс гадна Ажил гүйцэтгэх гэрээнээс нийгмийн даатгал авдаг нь компаниудад татвараа дийлэхгүй нөхцөл үүсэж байгаа, татварын өртэй учраас тендерт орж чадахгүй, улмаар данс хааж, хориг тавих нь тухайн компани үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болж өр ужиграх, ажил үйлчилгээгээ бартераар явуулах гээд хүндрэл бэрхшээл гарч байгааг дурдлаа. Дээрх нөхцөл байдлаас үүдэж барилгын салбарынхан Улаанбаатар хотын Мега төслүүдэд оролцох боломжгүй байгааг онцолсон юм. Түүнчлэн татвар төлдөг аж ахуйн нэгж цөөн учраас далд эдийн засгийг нэмэгдүүлж, энэ нь орлогоо мэдүүлж татвараа төлдөг нь хохироод төлдөггүй хожих нөхцөл бүрдэж байна, татвар төлөгчдийн татварын боловсрол сул байгаа талаар ч анхааралдаа авах хэрэгтэй байгаа талаар саналаа солилцлоо. Мөн Татварын багц хуулиудыг шинэчлэхдээ үндэслэлтэй тооцоо судалгаа, үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай гэдгийг онцолж улмаар дараах асуудлуудад санал нэгдэж холбогдох газруудад саналаа хүргүүлэхээр боллоо.


МБҮА ТББ-ын ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД ТАТВАР, САНХҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХАМТРАН АЖИЛЛАНА



МБҮА ТББ нь салбарын хууль эрх зүйн орчинд шинэчлэл хийх, олон улсын барилгын гэрээний зарчимд нийцүүлэн нэвтрүүлэх, барилгын салбарт сайн засаглалыг бий болгох, Гишүүн компаниудын компаниудын засаглал, өрсөлдөх чадварыг сайжруулах, мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, шинэ дэвшилтэт технологи, ноу-хауг нэвтрүүлэн нутагшуулах тогтолцоог бүрдүүлэх замаар салбарын чадавхыг сайжруулан хөгжүүлэх чиглэлд Гишүүн байгууллагуудаа байнга дэмжин, хамтран ажилладаг бөгөөд энэ ажлын хүрээнд 2025.06.02-ны өдөр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх Татварын Хөгжил Дэвшил Холбоо ТББ-ын Тэргүүн Б.Ганболд нар хамтран ажиллах санамж бичгийг зурлаа. Ингэснээр МБҮА ТББ нь Гишүүн байгууллагууддаа татвар санхүүгийн хууль тогтоомжийг сурталчлах, НББОУС, СТОУС-ыг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх чиглэлээр мэдлэг, мэдээллийг өгөх юм. Мөн байгууллагын татварын хяналт шалгалтын үед зөвлөгөө өгөх, Татварын

хэрэг маргаанд Татварын алба, Маргаан таслах зөвлөл, Шүүхийн байгууллагад төлөөлөх гэх мэтэд зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах юм.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД Э.БАТ-АМГАЛАН САЛБАРЫН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДТАЙ УУЛЗАХАД МБҮА ТББ САНАЛАА ТОДОРХОЙ ИЛЭРХИЙЛЛЭЭ



Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа болон газар хэлтсийн дарга нар салбарын Төрийн бус байгууллагуудын төлөөллүүдтэй 2025.08.29-ны өдөр уулзлаа. Сайд уулзалтын эхэнд салбарын хууль эрх зүйн шинэчлэлт, хийгдэж буй ажлуудын талаар товч мэдээлэл өгөөд улмаар салбарт тулгамдаж буй асуудлууд болоод ямар зүйл дээр өөрчлөлт шинэчлэлт хийхээр байгаа, юун дээр анхаарч ажиллах тал дээр барилгын салбарын удирдлага, төлөөллүүдтэй санал солилцож цаашид хэрхэн хамтран ажиллах талаар бодлого боловсруулж ажиллахаа илэрхийллээ.

Уулзалтын үеэр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх нь салбарын яамтай гэрээний дагуу үйл ажиллагаа эрхлэхэд тулгамдаж байгаа асуудал болоод барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахимд шилжүүлэх үйл ажиллагааг улам сайжруулан Зөвшөөрлийн нэгдсэн систем /https://license.mn// нэгдсэн системд нэвтрэх ажлыг зохион байгуулж үйл ажиллагааг жигдрүүлж байгаагаа онцоллоо. Мөн хууль эрх зүйн өөрчлөлт, салбарын хүний нөөцийн судалгаа болоод Дулаан шийдэл төслийн хүрээнд нягт хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа уламжилсан юм

БАРИЛГЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНЫ ҮЕЭР ГИШҮҮДИЙН САНАЛЫГ ТУСГУУЛАХ ТАЛ ДЭЭР АЖИЛЛАЛАА

Монгол Улсын барилгын салбарын хөгжил, шинэчлэлийн стратегид томоохон өөрчлөлт авчирахын тулд салбарын хууль эрх зүйн шинэчлэл, өөрчлөлт ихээхэн хамааралтай бөгөөд Барилгын ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай хууль, Орон сууцны ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга,Үндэсний орон сууцжуулалтын тухай зэрэг барилгын салбарын багц хуулийн төслүүдийг боловсруулан батлуулахаар салбарын яам, салбарын ТББ-уудтай хамтран Ажлын хэсэг гарган идэвхтэй ажиллаж байгаа билээ. Тус ажлын хүрээнд Хот



байгуулалт, барилга хот байгуулалтын яаманд 2025.09.26-ны өдөр Барилгын Ерөнхий хуулийн Ажлын хэсэг хуралдаж Барилгын Ерөнхий хуулийн төслийг ирэх 10-р сард ХЗДХЯаманд хүргүүлж, 11-р сард Засгийн газарт, 12-р сард УИХ-д өргөн барихаар төлөвлөж ажиллаж байгаа талаар ББМБЗГ-ын дарга Д.Энхбаатар танилцуулга хийж Гишүүдийн саналыг сонслоо. Иймд тус хуулийн төслийг өргөн барихтай холбогдуулан олон нийтийн саналын хүлээн авч байгаа бөгөөд эрхэм Гишүүд та бүхнийг Барилгын Ерөнхий хуулийн үзэл баримтлалд яаралтай саналаа өгөхийг хүсэж байна.